



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2017.12.18, ДАВАА ~ №242, 243 (788, 789)

~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~

ҮНЭ: 1000Т

Агаарын бохирдолтой тэмцэх ажлын хэрэгжилт

Гэр хорооллын 957 айл өрхийг шинэ орон сууцанд оруулжээ. > 2

Чанга яригчийн зах зээл дэх аварга өсөлт

Гуравдугаар улиралд борлуулалт жилийн өмнөхөөс 700 хувиар "үсэглээ". > 4



■ Даатгалынхан ухаалаг орон гэрт найдаж байна

■ Д.Камерон "Нэг зам, нэг бүс" сангийн удирдлагад оржээ

Ubinfo.mn сайт шилдэгт багтлаа

"Засгийн газрын мэдээ" сонины цахим хуудас Ubinfo.mn нь Монголын мэдээллийн шилдэг сайтуудын тавдугаарт бичигдлээ.

- Gogo.mn
- Xopom.com
- lkon.mn
- Caak.mn
- Ubinfo.mn
- Zалуu.com
- News.mn
- Peak.mn
- Medee.mn
- Dorgio.mn

Эх сурвалж: Alexa.com ©

ОНЦЛОХ

УЛС ТӨР

Ерөнхийлөгч үндэсний аюулгүй байдлын асуудлаар УИХ-д хаалттай мэдээлэл хийв. **УИХ-ын гишүүн Ж.Батзандан**, Л.Болд нар нээлттэй сонсгол зохион байгууллаа. **Эрүүл мэндийн даатгалын** үндэсний зөвлөлийн даргаар Д.Сарангэрэлийг томиллоо. **Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн** сайд Б.Батзориг ОХУ-д айлчиллаа. **ТЕГ-ын дарга асан Б.Хурцг** БНСУ-д суух Элчин сайдаар томилов.

ЭДИЙН ЗАСАГ

Автобензины импорт өнгөрсөн сарын байдлаар 32 хувиар өсөв. **Зэсийн ханш Нью-Йоркид** хоёр хувиар өсөж, фунт нь 3.11 ам.долларт хүрчээ. **"Е-Моние", "Хөвсгөл усан зам"** компанийн хувьцааны ханш 15 хувиар дээшлэв. **MSE ALL индекс 1166.71** нэгж болж 0.9 хувиар буурлаа. **China Shenhua Energy-ийн** нүүрсний борлуулалт өнгөрсөн сард 9.6 хувиар өсөв.

НИЙГЭМ

Ерөнхийлөгчийн зарлигаар Монголын Урчуудын эвлэлийг Сүхбаатарын одонгоор шагнав. **"Чингис хаан" нисэх** буудлынхан 1.2 сая дахь зорчигчдоо хүндэтгэл үзүүлэв. **Зүүнхараад зогсох галт** тэрэгний хөдөлгөөнийг хязгаарлажээ. **Эх, нялхсын эмнэлгийг** нярайн инкубатороор хангахаар боллоо. **АТГ-аас Зам, тээврийн** хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэд зөвлөмж өглөө.

ДЭЛХИЙ

Австрийн шинэ Засгийн газар ОХУ-ын эсрэг хоригийг цуцлахыг уриалсан байна. **Египет НҮБ-д Иерусалимыг** Израйлын нийслэлээр үл зөвшөөрөх санал оруулав. **Соня Ганди Конгресс** намын даргаас огцорсон ч парламентад үлдэхээ зарлалаа. **Сүүлийн санал асуулгаар** британчуудын олонх нь Европын холбонд үлдэх санал өгчээ. **Хятадын хойд нутаг 2019 онд** 50 хувь цэвэр халаалтад шилжиж, 74 сая тонн нүүрс хэмнэнэ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР
2017.12.18

-12° | -21°
ҮҮЛШИНЭ

ЦАГ АГААРЫН ДЭЛГЭРЖИГЧ МЭДЭЭЛИЙГ
8 ДУГААР НҮҮРЭЖ УНШИНА УУ.



Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

Нам дагасан зээл



Улс төрийн үзэл баримтлал, итгэл үнэмшил чухамдаа зээл авахад хэдийнэ албан бус шалгуур болжээ. Жижиг, дунд үйлдвэрлэлийн зээлийг нам харгалзан олгож байгаатай олон хүн эвлэрч чадахгүй байна. > 3

ЭДИЙН ЗАСАГ

Монголд 79.1 сая ам.доллар олгоно

Санхүүжилт ажлын 1-2 хоногийн дотор манай улсыг чиглэнэ

Г.Байгал
@baigalZGM

ОУВС-гийн Захирлуудын зөвлөл Монгол Улсад хэрэгжүүлж буй "Өргөтгөсөн

санхүүжилтийн хөтөлбөр"-ийн эхний улирлуудын үр дүнг үнэлэн, дараагийн шатны санхүүжилт олгохоор болсон байна. Энэ хүрээнд 79.1 сая ам.долларыг Монгол Улсад олгохоор болжээ. Сангийн яамны албаны эх сурвалжийн мэдээллээр уг санхүүжилт нь ажлын 1-2 хоногт багтаан Монголбанкны дансанд шилжих аж. "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн хүрээнд ОУВС-гаас олгох энэ санхүүжилт нь манай улсын төлбөрийн тэнцлийг сайжруулахад зарцуулагдах юм. Өнгөрсөн тавдугаар сарын 24-нд ОУВС-гийн Захирлуудын зөвлөл уг хөтөлбөрийг Монгол Улсад хэрэгжүүлэхээр шийдсний дараа эхний шатны санхүүжилт болох 38.6 сая ам.доллар Монголбанкны дансанд шилжсэн юм.

> 11

ЗГМ: ИНФОГРАФИК



НИЙГЭМ

Монголчууд 100 тэрбум төгрөгийг тамхинд зарцуулдаг

Монголчууд жилд 3.2 тэрбум ширхэг тамхи татдаг

Г.Оюунтөгс
@oyuuntugsZGM

Монгол Улсын нийт хүн амын 27.1 хувь нь тамхи татдаг бол НЭМҮТ-ийн хийсэн судалгаанд өсвөр үеийнхний 61.3 хувь нь тамхи татаж үзсэн хэмээн хариулжээ. Энэ нь таван хүүхэд тутмын гурав нь тамхи татаж үзсэн гэсэн үг юм. ДЭМБ-аас хийсэн судалгаагаар монголчууд жилд 3.2 тэрбум ширхэг тамхи

татдаг бөгөөд жилд дунджаар 100 тэрбум төгрөгөөр тамхи худалдан авдаг байна. Үүний 65 хувийг импортынх эзэлж буй. Уг нь Тамхины хяналтын тухай хуульд тамхины татварыг тасралтгүй нэмэгдүүлж, насанд хүрээгүй иргэнийг тамхинд орохоос сэргийлэх, тамхины хэрэглээг бууруулна хэмээн заасан байдаг. Гэвч бодит байдал дээр хуулийн хэрэгжилт хангалттай үр дүнд хүрч чадахгүй байгааг дээрх тоо баримт харуулж байна. Түүнчлэн утаат тамхитай тэмцэхийн тулд олон арга хэмжээ авч, зарим нь үр дүнгээ өгсөн ч бүтэлгүйтсэн төслүүд ч бас байгаа юм.

> 6



Хятадыг эдийн засгийн түрэмгийлэлд буруутгана

Деметри Севастопуло АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп даваа гарагт танилцуулах үндэсний аюулгүй байдлын стратегидаа Хятад улсыг эдийн засгийн түрэмгийлэлд буруутгахаар бэлтгэжээ. Тэрбээр Хятадын Ерөнхийлөгч Ши Жиньпинтэй харилцаагаа ашиглан худалдааны маргаанаа шийдэх оролдлого бүтэлгүйтсэний шинж тэмдэг юм. Уг баримт бичгийг мэдэх хүмүүсийн ярьснаар Трамп Хятадын талаар өмнөх засаг захиргаанаас хатуу байр суурь баримтлах бодолтой

байна. Албаны нэг хүн хэлэхдээ "Үндэсний аюулгүй байдлын стратегид Хятадыг бүх салбарт өрсөлдөгч гэж тодорхойлох байх. Өрсөлдөгчөөр зогсохгүй аюул занал, цаашилбал сөргөлдөгч гэж энэ захиргааны олон албан тушаалтан үздэг" хэмээсэн юм. Хоёр улсын Ерөнхийлөгч нар АНУ-д анх уулзах үед Трамп Хойд Солонгос болон худалдааны асуудлаар ямар нэг юм хийгээч гэсэн нь үр дүнд хүрээгүй бололтой.

> 9

MSE ALL 1166.71 0.9%	АЛТ 1256.74 0.3%	ЗЭС 6886 1.37%	10-ЧИНГИС БОНД 99.070 0.04%	5-ЧИНГИС БОНД 100.13 0.06%	АМ.ДОЛЛАР 2434.22	ЮАНЬ 368.44	РУБЛЬ 41.33
----------------------------	------------------------	----------------------	-----------------------------------	----------------------------------	----------------------	----------------	----------------

Улс төр

ЗАСГИЙН ГАЗАР

Агаарын бохирдолтой тэмцэх ажлын хэрэгжилт



Төсөл хэрэгжиж эхэлсэн сүүлийн гурван жилийн хугацаанд нийтдээ 85190 хүн ам бүхий 17667 нэгж талбарын 1615.8 га талбай хамрагдсан байна.

Б.Ганбаяр/ЗГМ ©

Гэр хорооллын 957 айл өрхийг шинэ орон сууцанд оруулжээ

Б.Даваатогтох
@dataZGM

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга өнгөрсөн баасан гарагийн чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож, улс орны үндэсний аюулгүй байдлын асуудлаар хаалттай мэдээлэл хийсэн. Үүнээс үүдэн Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн гэр хорооллын дахин төлөвлөлт, орон сууцжуулах хөтөлбөрийн талаар мэдээлэл хойшилсон юм.

Засгийн газраас Улаанбаатар хотын агаар болон хөрсний бохирдлыг тодорхой хэмжээгээр бууруулах зорилгоор өнөөдрийн байдлаар VII хороолол, МҮОНРТ-ийн орчмын гэр хорооллыг инженерийн дэд бүтцэд холбох, VII, XIV хороололд

2592 айлын орон сууц барих төслийг Хятадын Эксим банкны 100 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж байна. Энэхүү төслийн хүрээнд Сүхбаатар дүүргийн VII хороололд 1296, Баянзүрх дүүргийн XIV хороололд 792 айлын орон сууцыг ашиглалтад оруулаад байгаа аж. VII хорооллын инженерийн шугам гүйцэтгэл 92.1 хувьтай байгаа бол МҮОНРТ-ийн орчмын хорооллын инженерийн шугам гүйцэтгэл нь газар чөлөөлөх ажлаас шалтгаалан 38 хувьтай байгааг дээрх мэдээлэл дурджээ. Харин VII хороолол, МҮОНРТ-ийн орчмын хорооллыг цахилгааны эх үүсвэрээр хангах 24.3 км агаарын шугам болон “Улаанбаатар” дэд станцын өргөтгөл, “Радио телевиз” дэд станцын угсралтын ажил бүрэн хийгдсэн байна.

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, бүтээн байгуулалтын ажлын хүрээнд иргэдийг эрүүл, аюулгүй орчинд

амьдрах эрхийн баталгааг хангах зорилгоор 2013 оноос эхлэн нийслэлийн гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах 24 байршилд, 75 хэсэгчилсэн талбайд “Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл”-ийн үйл ажиллагааг хэрэгжүүлжээ. Төсөл хэрэгжиж эхэлсэн сүүлийн гурван жилийн хугацаанд нийтдээ 85190 хүн ам бүхий 17667 нэгж талбарын 1615.8 га талбай хамрагдсан байна. Энэ нь нийслэлийн гэр хорооллын нутаг дэвсгэрийн 15 хувь, гэр хорооллын хүн амын 10 хувийг хамарч байгаа аж. Төсөл хэрэгжүүлэх талбайд орон сууцны барилга, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажилд зориулан нийт 1472 нэгж талбарын газрыг чөлөөлж, гэр хорооллын 957 айл өрхийг шинэ орон сууцанд, 491 өрхийн иргэдийг түрээсийн орон сууцаар ханган, 24 өрхийн газрыг бэлэн мөнгөөр худалдан авсан байна. Энэ хугацаанд төсөл хэрэгжүүлэгчид 9654 айлын орон сууцны барилга угсралтын ажлыг эхлүүлсэн бөгөөд 2014 онд 960,

2015 онд 1656, 2016 онд 2273 айлын орон сууцыг ашиглалтад оруулжээ.

● VII, XIV хороололд 2592 айлын орон сууц барих төслийг Хятадын Эксим банкны 100 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж байна.

● Сүхбаатар дүүргийн VII хороололд 1296, Баянзүрх дүүргийн XIV хороололд 792 айлын орон сууцыг ашиглалтад оруулаад байгаа аж.

● 24 өрхийн газрыг бэлэн мөнгөөр худалдан авчээ.

Үүнээс гадна БНХАУ-ын Засгийн газраас олгох 350 сая юанийн буцалтгүй тусламжийг

“Хүн амын орон сууцны хэрэгцээг хангах зорилгоор нэгдсэн бодлого боловсруулах, “Хямд өртөгтэй орон сууц” үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэхэд зарцуулахаар төлөвлөжээ. Энэ хүрээнд нийслэлд 1000 айлын түр суурьших орон сууцыг барихаар “Ногоон нуур орчмын түр суурьших орон сууцны хотхон” төслийг хэрэгжүүлэхээр ажлыг эхлүүлээд байгаа аж. Хятадын талтай гэрээний нөхцөлийг тохирох, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, төслийг яаралтай эхлүүлэхээр ажиллаж буйгаа Ерөнхий сайд мэдээлэлдээ онцолжээ.

Мөн Хятадаас Монгол Улсад олгох хоёр тэрбум юанийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн хүрээнд хэрэгжүүлэх инженерийн болон нийгмийн дэд бүтэц бүхий бичил дэд төвүүд байгуулна. Хэрэв бодит хэрэг болж чадвал Улаанбаатар хотын агаар, хөрсний бохирдол 30 хувиар буурна гэж үзэж байгаа аж. [ЗГМ]

ПАРЛАМЕНТ

ЭМД-ын үндэсний зөвлөлийг Д.Сарангэрэл тэргүүлнэ

Б.Тогтох
ЗГМ

УИХ-ын чуулганы баасан гарагийн нэгдсэн хуралдаанаар Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн зарим гишүүнийг томилж, чөлөөлөх тухай УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцэж, батлав. Эрүүл мэндийн даатгалын үндэсний

зөвлөлийн гишүүн болох Б.Чойжилсүрэн, А.Цогцэцэг, Н.Номтойбаяр нарыг чөлөөлж, түүний оронд Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг нарыг томилло. Харин тус зөвлөлийн даргаар Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэлийг томилло. Тэрбээр “Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар

бие даан ажиллахаар боллоо. Энэ бол МАН-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан асуудал юм. Энэ газрыг бие даасан статустай болгосноор төрийн данхар бүтцийг бий болгож байгаа зүйл огтхон ч биш. Өөрөөр хэлбэл, ЭМД-ын санд мөнгөө төлж байгаа иргэд эрүүл мэндийн үйлчилгээг бүрэн авдаг болоход чиглэж ажиллана. Өнөөдөр өндөр өр-

төгтэй эмнэлгийн тусламж үйлчилгээнээс болж ард иргэдийн нуруун дээр томоохон ачаалал ирж байна. Энэ ачааллыг хөнгөлөх нь тус газрын үндсэн үүрэг болох юм. Хоёрдугаарт, эмийн үнэ тэнгэрт хадсан байна. Бид Ази тивдээ 3-5 дахин өндөр үнэтэй эм хэрэглэж байгаа. Тиймээс нийтлэг хэрэглэгддэг эмийн үнийг 30-80 хувь хөнгөлөх юм. Үүнээс гадна анхан

шатны эмнэлгийн үйлчилгээ явуулж байгаа газруудын үйл ажиллагааг дэмжинэ. Ингэхдээ цалин мөнгөний нэмэгдэл бус эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулахад чиглэх юм” хэмээн байр сууриа илэрхийлэв.

Үргэлжлүүлэн хаалттай горимоор хуралдаж, Тагнуулын ерөнхий газрын дарга асан Б.Хурцыг БНСУ-д суух Элчин сайдаар томилло. [ЗГМ]

ТОВЧХОН

» ЗАРЛИГ

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга зарлиг гаргаж, Монгол Улсад орчин үеийн дүрслэх урлаг үүсэж хөгжсөний 75 жилийн ойг тохиолдуулан Монголын Урчуудын эвлэлийг Сүхбаатарын одонгоор шагнав. Шагналыг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга З.Энхболд өчигдөр гардууллаа.

» ХАМТЫН АЖИЛЛАГАА

Македонийн Гадаад хэргийн сайд Никола Димитров Монгол Улсаас тус улсад суугаа Элчин сайд Д.Батсайханыг хүлээн авч уулзав. Уулзалтын үеэр хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх талаар санал солилцов.

» ЗАСГИЙН ГАЗАР

Шадар сайд Ө.Энхтүвшин Стандарт, хэмжил зүйн газарт ажиллалаа. Монгол Улсад өнөөдрийн байдлаар 6196 стандарт мөрдөгдөж байгаа. Үүнээс 3011-ийг заавал, 3185-ыг сонгон хэрэглэх боломжтойгоор нэвтрүүлжээ. Эдгээр стандартын 34 хувь нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ба энэ нь Монголын бараа бүтээгдэхүүн экспортод гарах чухал хөшүүрэг юм.

» АЙЛЧЛАЛ

ХХААХУ-ийн сайд Б.Батзориг ОХУ-д ажлын айлчлал хийж, тус улсын Хөдөө аж ахуйн орлогч сайд Е.В.Громькотой уулзлаа. Уулзалтын үеэр газар тариалангийн бүсэд үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах үүднээс ойн зурвас байгуулах, техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх, усалгаатай газар тариалангийн талбайг нэмэгдүүлэх чиглэлд ОХУ-тай хамтарч ажиллах боломжуудын талаар хоёр тал харилцан санал солилцов.

» ХУРАЛ

Мэдээллийн технологийн бодлогын зөвлөл хуралдаж, журмын төсөл, ирэх оны үйл ажиллагааны чиглэл, гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, цаашдын зорилтын талаар хэлэлцэв. ЗГХЭГ-ын дарга Г.Занданшатар төрийн байгууллагуудад цахим засаг, мэдээллийн технологийн чиглэлээр улсын болон гадаадын зээл, тусламжаар төсөл, хөтөлбөр хэрэгжиж байгаа ч нэгдсэн бодлого, төлөвлөлтгүй, уялдаа холбоо хангалтгүй байгааг анхаарууллаа.

» АТГ

АТГ-аас Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэд өглөө. Зөвлөмжид албан тушаалтан томилогдсоноос хойш хуульд заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах чиглэлээр салбарын хэмжээнд зохион байгуулалтын арга хэмжээ авах, мэдүүлгээ хугацаанд нь гаргаагүй албан тушаалтанд хариуцлага тооцох, хяналтыг сайжруулах талаар арга хэмжээ авахыг тусгасан байна.

ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА

Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжилгатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал

» INFO@ZASAG.CO

Утас: 99903584 хаягаар бидэнтэй холбогдоно уу.

ЭВРИКА

Bloomberg
TV Mongolia

“Эврика” нэвтрүүлгээр урлагийн ертөнцийн амин сүнс, цохилох зүрх болсон гайхшруулж, оюун бодлыг сорьж, алмайруулж чаддаг гоц авьяастнуудтай уулзуулдаг.

Энэ удаагийн дугаарт Элмгрин ба Драгсет гэж олонд танигдсан Европын уран бүтээлч Майкл Элмгрин, Ингар Драгсет нарыг танилцуулах болно. Өнгөрсөн 20 жилийн турш тэд Техасаас авахуулаад Трафальгарын талбай, Бээжингээс Берлин, Венецийн Биенналияс Нью-Йорк гээд дэлхийн өнцөг булан бүрийн үзэгчдэд санаанд оромгүй бүтээлүүдээрээ бэлэг барьсаар ирсэн юм.

Пүрэв гараг /2017.12.21/

20:30

11:30 Баасан гараг

09:30/20:00 Бямба гараг

16:30/22:30 Ням гараг

Нийтлэлчийн булан

Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжилд дарга саад болно

Б.Баяртогтох
@bayartogtokhZGM

Жижиг, дунд үйлдвэрлэлийн чиглэлээр өдгөө 70 гаруй мянган аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Энэ салбарт сүүлийн долоон жилийн хугацаанд нийт 37 мянган ажлын байр бий болсон бөгөөд дийлэнх нь төв, суурин газар бүртгэгджээ. Дээрх 70 мянган үйлдвэрлэгч өнгөрсөн онд 79.9 тэрбум төгрөгтэй тэнцэх зээлийн дэмжлэг авч, хямралын үед үйл ажиллагаагаа зогсоолгүй аваад гарсан байна.

Харин хүн ам цөөн, зах зээл багатай сумын төвд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа иргэд ихээхэн гомдолтой сууна. Тухайлбал, Завхан аймгийн Эрдэнэхайрхан суманд нарийн ногоо тариалж, өрхийн үйлдвэрлэл эрхэлж ирсэн Г.Оюун “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн



Г.Оюун “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн зээлээс жирийн иргэд хүртэж чаддаггүй” гэв. Тэрбээр “Сумын захиргаанд танил талтай нь зээл аваад зориулалтын бусаар ашигладаг. Гэтэл жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэх гээд зүтгэж байгаа нь хоосон хоцордог” хэмээн нэмж хэллээ.

С.Батсайхан / ЗГМ©

Нам дагасан зээл

зээлээс жирийн иргэд хүртэж чаддаггүй” гэв. Тэрбээр “Сумын захиргаанд танил талтай нь зээл аваад зориулалтын бусаар ашигладаг. Гэтэл жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэх гээд зүтгэж байгаа нь хоосон хоцордог” хэмээн нэмж хэллээ.

Халамж нэхэх авч хайр даадаггүй салбарын нэг болоод байна

Жижиг, дунд үйлдвэрлэлийн зээлтэй холбоотой зөрчил орон нутагт буурахгүй байна. Хөнгөлөлттэй зээлийг зориулалтын бусаар ашигласан, эзнээ олоогүй гэх хэл ам байнга гарах болсон. Үүнийг зарим нь байх ёстой үзэгдэл мэт үл тоох аж. Завхан аймагтай хаяа нийлэн орших Говь-Алтай аймагт ч байдал дээрдсэнгүй. Тус аймагт жижиг, дунд үйлдвэрлэлийн зээлийг нам харгалзан олгож байгаатай олон хүн эвлэрч

чадахгүй байна. Өөрөөр хэлбэл, улс төрийн үзэл баримтлал, итгэл үнэмшил чухамдаа зээл авахад албан бус шалгуур хэдийнэ болжээ. Ийм байдал ихэд хавтгайрч, бизнесийн орчинд ан цав үүсгэсээр, Жижиг, дунд үйлдвэрлэлийн зээл ийнхүү орон нутагт нам дагадаг болсон нь “зуршил” болон тогтжээ. Увс, Баянхонгор аймагт ч дээрх байдал давтагдсаар.

Төрөөс жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлд гар таталгүй хөрөнгө хуваарилж ирсэн. Өнгөрсөн дөрвөн жилд Хөгжлийн банкны санхүүжилтээр хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн салбарт 1600-гаад аж ахуйн нэгж, иргэнд нийт 820 гаруй тэрбум төгрөгийн зээл олгосон. Гэтэл орон нутагт жижиг, дунд үйлдвэрлэлийн салбар дорвитой тэлж, хөл дээрээ зогсож чадсан нь ховор. Халамж нэхэх авч хайр даадаггүй салбарын нэг болоод байна. Ялангуяа, засаг захиргааны хамгийн бага нэгж болох багийн дараа орох сумын төвд үйлдвэрлэл хөгжиж, үр дүнд нь ажлын байр бий болсон жишээ, баримт хуруу дарам цөөн.

Азийн хөгжлийн банк тэргүү-

тэй олон улсын байгууллага, хандивлагч орнууд жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэх гэж манайхыг чамгүй хугацаанд бордож ирсэн. Гэвч үр дүн төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй байгаа тул зарим байгууллага нүүр буруулахад хүрч байна. Монголбанкны судалгаанд, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд улс төрийн байдал нөлөөлж байгааг дурджээ. Мөн төрийн албаны хүнд суртал, хээл хахууль ихээхэн хүндрэл болдог гэж үзсэн байна. Сум болгон орон нутаг хөгжүүлэх сангаасаа жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зээл жил бүр иргэддээ хүртээх болсон. Үүнийг хэнд олгохоо эцсийн дүндээ Засаг дарга л шийддэг. Энэ байдал нь өнөөдөр үйлдвэрлэлийг хөгжүүлэх зээл нөгөө талдаа улстөржих учир шалтгааны ул суурь болжээ.

Хөвсгөлийн Мөрөн хотноо болсон “Хангайн бүсийн өрсөлдөх чадвар”-ын чуулганы хамгийн ширүүхэн хэлэлцүүлэг мөн л жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх хүрээнд өрнөж байлаа. Тухайн үед хуралд оролцсон орон нутгийн үйлдвэрлэгчид зээл жинхэнэ эзэндээ хүрэхгүй байгаа,

зээлтэй холбоотой мэдээллийг хав дардаг, эсвэл танил танилдаа шууд олгодог хэмээн хатуухан шүүмжилж байсан юм. Үүнийг Булган, Архангай аймгаас ирсэн жижиг, дундынхан үгүйсгэсэнгүй. Угтаа жижиг, дунд үйлдвэрлэл хөгжиж байж эдийн засаг төрөлжиж, орон нутагт ажлын байр нэмэгдэж, өрхийн амьжиргаа дээшилнэ. Аймаг болгон иргэдээ ажилтай, орлоготой байлгах мөрийн хөтөлбөр боловсруулсан ч амьдрал дээр үүний үр дүн биеллээ олж чадахгүй байна.

Олон тулгуурт эдийн засгийн тогтолцоотой, эрдэс бүтээгдэхүүний үнийн уналтад савлаад байдаггүй эдийн засагтай болоход жижиг, дунд үйлдвэрлэлийн оролцоо чухал. Үйлдвэрлэл хөгжиж чадсанаар гадаад худалдаа алдагдалтай бус ашигтай гарах нь зүй тогтол. Ингэснээр шинэ ажлын байр бий болж, гадагшаа урсгах хөрөнгийн урсгал дотоодод баялаг болж үлдэнэ. Зөвхөн баялаг болоод зогсохгүй хөгжил болж хот, хөдөөгийн ялгаа арилна. Үүний цаана ажилгүйдэл буурч, ядуурал багасна. Гэтэл жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэх гэж зүтгэх иргэдэд зорилтот зээл

хүрэхгүй байгаа нь дээрх цагийг улам холдуулна гэсэн үг.

Үндэсний статистикийн хороо болон Дэлхийн банкны хамт-

● **Жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарт өдгөө 70 гаруй мянган аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна.**

● **Өнгөрсөн дөрвөн жилд Хөгжлийн банкны санхүүжилтээр хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн салбарт 1600-гаад аж ахуйн нэгж, иргэнд нийт 820 гаруй тэрбум төгрөгийн зээл олгосон.**

● **Жижиг, дунд үйлдвэрлэлийн зээл орон нутагт нам дагадаг болсон нь “зуршил” болон тогтжээ. Увс, Баянхонгор аймагт ч байдал давтагдсаар.**

ран тооцсон судалгаагаар, Хот, хөдөөгийн хүн амын амьжиргааны түвшинг харьцуулахад орон нутагт ядуурал илүү нэмэгджээ. Хэрэв жижиг, дунд үйлдвэрлэлийн зээл эзнээ олж, улстөржөөгүй бол ядуурлын үзүүлэлт арай л бага дүнтэй гарах байсан болов уу. Төрөөс жижиг, дунд үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг гааль, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлж ирсэн. Хөнгөлөлт, чөлөөлөлт нь тус салбарыг төрөөс дэмжих хамгийн бодит дэмжлэг. Гэвч үүний ашиг тус сум, орон нутагт дорвитой гарч чадахгүй өдий хүрэв. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд олгож байгаа зээлийн дээд хэмжээ 50 сая төгрөг байсныг 500 сая төгрөгт хүргэн нэмэгдүүлж, зээлийн хугацааг сунгаж, хүүг нь нэг оронтой болгон бууруулж байлаа. Энэ салбарыг эргээд харахад дэмжлэг дутаагүй. Хамгийн сайн нөхцөл, хямд хүүтэй зээл, уян хатан татварын бодлого төр бүрдүүлэх гэж хичээсэн байна. Харин төрөө орон нутагт төлөөлөх хүмүүс төөрөгдөл үүсгэж, хөдөөгийн хөгжлөө өөрсдөө хойш татах аж. [ЗГМ]

УХААРАЛ ХАЙРЛАХ УРАН ШОГ

Өршөөл гуйлт



Херлуф Бидstrup Уран шог©

Технологи

Хиаоми-гийн ухаалаг цоож

Халааснаасаа түлхүүр гаргаж цоожинд шургуулах, хаа нэгтээ мартсан түлхүүрээ хайх зэрэг түвэг бэрхшээлээс салгаж өгөх ухаалаг цоожны хэрэглээ өдөр ирэх тусам өссөөр. Ийм цоожны нэр төрлийг БНХАУ-ын Xiaomi компанийн Vima Smart Lock Cylinder нэгээр баяжууллаа.

Энэхүү ухаалаг цоожийг ажиллуулахын тулд өрөөнд нэвтрэх тусгай түлхүүр үүсгэдэг программ хангамжийг ухаалаг утсанд суулгахад л хангалттай. Xiaomi-гийн Vima Smart Lock Cylinder нь хэрэглээнд нэвтэрсэн бусад төрлийн ухаалаг цоожноос өвөрмөц ялгаатай. Нэгдүгээрт, Vima Smart Lock Cylinder нь нарийндаа бүтэн цоож бус, ердөө түлхүүр шургуулдаг “зүрхэвч” хэсэг.



Уг “зүрхэвч” нь зөвшөөрөлгүй этгээд түлхүүр шургуулахаас хамгаалах давхар хамгаалалттай. Хаалга онгойлгоход ухаалаг утасны зэрэгцээ тусгай дижитал код тайлсан нөхцөлд цоожийг онгойлгох 128 битийн шифрлэх чип суулгасан металл түлхүүр ашиглаж болно.

Vima Smart Lock Cylinder-г өөр өөр өнгөөр ялгасан таван ийм түлхүүр дагалдана. Цоож тайлж нэвтрэх хүмүүст гарах энэхүү түлхүүрийн ачаар айл юу албан газарт яг хэн нэвтэрч байгааг алсаас мэдэж болно. Ухаалаг утсанд суулгасан мобайл программ хэрэглэгч нартаа хэдэн цаг, минутад хэний түлхүүрээр цоож нээгдэж буйг мэдээлж байх юм. Аль нэг түлхүүрийг хаяж гэсэн тохиолдолд цоож солих шаардлагагүй. Программдаа хаягдсан түлхүүрийн хаалга нээх эрхийг түр юм уу бүрмөсөн зогсоох боломжтой. Ирэх оны нэгдүгээр сарын 28-наас БНХАУ-д худалдаалж эхлэх энэхүү цилиндр “зүрхэвч” ердөө 27-хон ам.долларын үнэтэй. Хэрэглээнд түгээмэл тархсан олон төрлийн цоожинд тааруулан Vima Smart Lock Cylinder-ийг ялгаатай дөрвөн загвараар үйлдвэрлэнэ. [ЗГМ]



Гуравдугаар улиралд зарагдсан нийт ухаалаг чанга яригчийн 75 хувь нь ердөө Умард Америкийн зах зээлд оногдож байна.

BBM ©

Чанга яригчийн зах зээл дэх аварга өсөлт

Гуравдугаар улиралд борлуулалт жилийн өмнөхөөс 700 хувиар “үсэрлээ”

Г.Очирбат
ЗГМ

Дэлхийн ухаалаг спикер буюу чанга яригчийн зах зээлийн гуравдугаар улирлын статистикийг судалгааны Strategy Analytics компани гаргалаа.

Уг статистикаас үзвэл чанга

яригчийн зах зээл дэх нэн шинэ төрөл зүйлийн борлуулалт энэ онд гэнэтийн “тэсрэлт” бүхий өсөлттэй байна.

Жилийн өмнө буюу 2016 оны гуравдугаар улиралд дэлхий даяар нийт 900 мянган ширхэг ухаалаг чанга яригч зарагджээ. Харин энэ оны гуравдугаар улиралд энэ тоо 7.4 сая ширхэг болж, борлуулалт 700 хувиар “үсэрлээ”.

Энэхүү зах зээлд Amazon хуучин хэвээр ноёлж гуравдугаар улиралд таван сая ширхэг ухаалаг спикер борлуулав. Гэхдээ зах зээлд тус компанийн эзлэх хэмжээ 93.5-аас 66.9 болж эрс буурчээ.

Хоёрдугаар байранд 1.9 сая ширхэг төхөөрөмж борлуулж,

нийт зах зээлийн 25.3 хувийг эзэлж буй Google оров. Энэ хоёр компани нийлээд дэлхийн ухаалаг чанга яригчийн зах зээлийн 92.2 хувийг атгаж байна.

Гуравдугаар улиралд зарагдсан нийт ухаалаг чанга яригчийн 75 хувь нь ердөө Умард Америкийн зах зээлд оногдсон ч цаашдаа энэ үзүүлэлт буурах хандлагатай байгаа юм. Учир нь шинэ төрлийн бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ Европ, Азийн зах зээлд хурдацтай нэмэгдэж байна. Ялангуяа БНХАУ-д гуравдугаар улиралд Alibaba, Xiaomi, JD.com зэрэг дотоодын үйлдвэрлэгчийн загвар борлуулалтаараа тэргүүлээ.

“Harman Kardon, Sony, Sonos зэрэг шинэ тоглогч ухаалаг

чанга яригчийн зах зээлд хүч түрж буйтай уялдан өрсөлдөөн эрс ширүүснэ” хэмээн Strategy Analytics-ын шинжээч Дэвид Уоткинс тайлбарлав. “Эдгээр компани аудио бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр Amazon, Google хоёроос илүү баялаг түүхтэй. Цахиурын хөндийн аваргууд манлай загваруудынхаа дууны чанарыг сайжруулах замаар хариу барьж байна. Гэхдээ Amazon, Google хоёрын үнээр өрсөлдөх чадвартай Echo Dot, Google Home Mini хэмээх бүтээгдэхүүнүүд ойрын ирээдүйд зах зээлд нэг хэсэгтээ ноёлох байх” хэмээн шинжээч нэмж өгүүллээ.

Ухаалаг чанга яригч ашиглаж буй хамгийн түгээмэл дуут

туслагч нь Amazon Alexa, Google Assistant хоёр. Үйлдвэрлэгчид энэ хоёрын аль нэгийг, эсвэл хоёуланг нь дэмждэг шинэ бүтээгдэхүүн гаргах хэрээр ирэх онд өрсөлдөөн бүр ширүүснэ. Apple-ийн Siri-д суурилсан HomePod ухаалаг спикер шинэ жилийн баярын үеэр гарах ёстой байсан ч амжсангүй, ирэх онд худалдаанд гарахаар боллоо. Тус компани хиймэл оюун, виртуал туслагч хөгжүүлэх өрсөлдөөнд Amazon, Google хоёрын араас сүүл мушгиж явна.

Samsung компани мөн өөрийн хөгжүүлдэг Bixby дуут туслагч удирдаж ажиллуулах цогц систем чухам энэ үед нийтийн хэрэглээ болж байна. [ЗГМ]

Дроны холбооны дэд бүтэц

БНХАУ-ын Huawei Wireless X labs компани дроны холбооны дэд бүтэц үүсгэж хөгжүүлэх зорилготой Digital Sky Initiative буюу “Дижитал тэнгэр” төсөл эхлүүлж буйгаа мэдэгдлээ. Орчин үед дрон буюу нисгэгчгүй нисэх төхөөрөмж тээвэр, хөдөө аж ахуй, дэд бүтэц, онцгой байдлын аврах алба, зугаа цэнгэл зэрэг төрөл бүрийн салбарт чухал үүрэгтэй болж хувирлаа. Гэвч технологи хөгжих хэрээр дрон болон зайн удирдлагын төхөөрөмж хоёрыг холбож өгдөг хоёр цэгт холбооны арга шаардлага хангахаа больж байна. Үүний зэрэгцээ дроны тоо олширсон нь холбооны дохио давхцах эрсдэлийг ихэсгэлээ.

“Дижитал тэнгэр” санаачилга дээр өгүүлсэн бэрхшээлийг шийдвэрлэх зорилготой. Уг хөтөлбөрийн хүрээнд 300 метрийн

орчинд дроны найдвартай холбоо хангах нөхцөл бүрдүүлж өгнө. Ийм нөхцөл бүрдсэнээр нисэж буй дрон агаарт өөр хоорондоо болон оператортой өгөгдөл саадгүй солилцох юм. Холбооны шинэ систем нь дрон нисэх үнэмлэхүй оновчтой маршрутыг тодорхойлж, илүү үр дүнтэй, хэмнэлттэй нислэг болгоно.

Хятадын компани төслөө гурван үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Эхний шатанд холбооны сүлжээнд холбогдох чадвартай дроны туршилтын талбай байгуулж, үүрэн холбооны сүлжээнд тулгуурлаж удирдах стандартын суурь бий болгоно. Энэхүү шат 2017-2018 онд хэрэгжих юм.

Харин 2019-2020 оны хооронд хэрэгжих хоёрдугаар шатанд ашиглалтын туршилт эхлүүлж,



бага хэмжээгээр арилжааны хэрэглээнд нэвтрүүлнэ. Уг шатанд дроны холбооны сүлжээг таваас дээш улсад нэвтрүүлэхээр төлөвлөж байна.

Сүүлийн гуравдугаар шат

2020 оноос хойш эхлэх ёстой. Уг шатанд агаарын орон зайн дам бүсэд дроны зориулалттай дижитал сүлжээг арилжааны зориулалтаар нийтлэг ашиглах хэрэг юм. [ЗГМ]

Line-of-Sight) буюу шууд нүдэнд үзэгдэх хязгаараас алсад, их өгөгдөл дамжуулах аргаар дроныг удирдаж ажиллуулах цогц систем чухам энэ үед нийтийн хэрэглээ болох юм. [ЗГМ]

Криптовалютын төлбөр тооцооны үйлчилгээг нэвтрүүлнэ

Хэмжээгээр АНУ-д хоёрдугаарт ордог банкнаас тус улсын патентын албанд гаргасан хүсэлт нь тус банк гол хувьцаа эзэмшигч нартаа дөхөм үзүүлэхээс урьдаар криптовалютын ирээдүйд анхаарч буйг харууллаа.

Bank of America криптовалютын шилжүүлэг, хөрвүүлэг хийх хиймэл оюун ухааны удирдлага бүхий автоматжуулсан системийн патент авах хүсэлт тавианд байна. Уг системийг ажиллуулах алгоритм нь биржийн ханш, өгөгдөлд тулгуурлан нэг криптовалютыг нөгөөд нь хөрвүүлэх чадвартай.

Системийн хэрэглэгч талын

хэсэг нь банкны үйлчлүүлэгч криптовалютын хадгаламжаа эрхлэн хөтлөхөд тусална. Харин хоёр хэсгээс бүрдэх үйлчилгээний хэсэг нь шифрлэсэн валют солилцох криптовалют, хоёрдах хэсэгт үйлчлүүлэгч нараас тухайн мөчид шаардах өөр төрлийн криптовалют хадгалагдаж явна. Шилжүүлэг хиймэгц хиймэл оюунт систем үйлчлүүлэгчийн түрийвчнээс зохих валютыг татна.

Уг систем гадаад эх үүсвэрүүдээс орж ирсэн мэдээлэлд тулгуурлан дотоод ханш үүсгэн, гүйцэтгэж буй арилжааны

эрсдэлийг үнэлж, эрсдэлтэй ажиллагааг ялган тодорхойлох чадвартай.

Мөн компанийн үйлчлүүлэгч нар криптовалютаар олон улсын төлбөр тооцоо хийх, шилжүүлэг хүлээн авч буй талд шаардлагатай төлбөрийг дотоод ханшаар тооцон крипто юм уу энгийн валютаар олгох боломжтой.

Уг тогтолцоог гол нь компанийн үйлчлүүлэгч нарт зориулан бүтээж буйг патентын өргөдөлд тайлбарлажээ. Bank of America патентынхаа дагуу криптовалютын төлбөр тооцооны үйлчилгээг нэвтрүүлэх тов одоогоор тодорхойгүй байна. [ЗГМ]

5G холболтын тоо 2023 онд нэг тэрбумд хүрнэ

Шведийн Ericsson компани арваннэгдүгээр сард гаргасан Ericsson Mobility тайланд үндэслэн ойрын жилүүдэд дэлхийн хөдөлгөөнт холбооны технологийн хэтийн төлөвийг тооцоолж үзлээ. Дөрөвдүгээр үеийн LTE сүлжээ энэ оны эцэст дэлхийн үүрэн холбооны үйлчилгээний гол төрөл болж хувирна. Харин 2023 он гэхэд манай гарагийн хүн амын 85 хувь нь уг сүлжээний хэрэглэгч болж LTE холболтын тоо 5.5 тэрбумд хүрэх юм.

Ирэх хэдэн жилээс тавдугаар үеийн 5G систем хэрэглээнд идэвхтэй нэвтрэх эхэлнэ. Арилжааны зориулалттай анхны 5G сүлжээ 2019 оноос ажиллаж

ирэх 10 жилийн эцсээр дэлхийн нийтийн хэрэглээ болж хувирна. Шинэ үеийн 5G сүлжээний холболтын тоо 2023 онд нэг тэрбумд хүрнэ хэмээн Ericsson тооцоолж байна. Ердөө зургаахан жилийн дараа 5G сүлжээг манай гарагийн хүний амын 20-иос илүү хувь нь хэрэглэх болно.

Холбооны нэн дэвшилтэт технологийн нэвтрэх хэрээр мульти-медиа контент, төрөл бүрийн видео үйлчилгээний хэрэглээ аварга өсөх төлөвтэй. Төрөл бүрийн стриминг үйлчилгээний өсөлтөөс шалтгаалан дэлхийн мобайл граффийкийн хэмжээ 2023 он гэхэд одоогийнхоос найм дахин ихсэж, 110 эксабит хүрнэ хэмээн тооцоолжээ. [ЗГМ]

[ЗГМ СОНИН]

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилго болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН

Ерөнхий эрхлэгч
Баатарын ДУЛАМХОРЛОО

Зөвлөх
Шатарбалын ДАВААДОРЖ

Орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас: 99903584

РЕДАКЦИ

Улс төр, нийгэм, эрэн сурвалжаах мэдээллийн алба
Эдитор Б.Даваатогтох
Утас: 99901637

Эдийн засаг, уул уурхайн мэдээллийн алба
Эдитор Б.Баяртогтох
Утас: 99901532

Цахим контент, бүтээлч үйлдвэрлэлийн алба
Эдитор Г.Балрсайхан
Утас: 99903574

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Э.Энхбаатар
Утас: 99903578

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
I хороо, Энхтайвны өргөн чөлөө,
“Бло Скай тауэр” 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар. 1024
Утас: 70103131,
Факс: 70106065

ЦАХИМ ХУВИЛБАР

ubinfo.mn

Дугаарын удирдагч
Б.Даваатогтох



Сурталчилгаа

УУЛ УУРХАЙ

Ил тод уурхайн далд сүлжээ

Бичил уурхайчид-тай болох уу, бүр олон нинжатай болох уу гэдгийг тодорхойлно

Ч.Отгочулуу
Эдийн засагч

1990-ээд оны сүүлээс 2000 оны эхэн хүртэл зундаа ган, өвөлдөө зуд нүүрлэж олон жил үргэлжилсэн олон мянган малчин, тариаланч өрхүүд амьжиргааны эх үүсвэргүй болсноос “нинжа” буюу хууль бусаар ашигт малтмал олборлон амь зуудаг нийгмийн бүлэг үүсжээ. Тэд хялбар, энгийн технологиор ашиглаж болохуйц алт, нүүрс, жонш, төмөр, давс, чулуужсан мод, ашигт малтмалын орд, илэрцүүд мөн зарим тохиолдолд самар, эмийн ховор ургамал, хориотой ан зэрэг байгалийн баялгуудыг өнөө болтол олборлож, ашиглаж байна. Үүнээс хамгийн олон хууль бус ашигт малтмал олборлогчдыг багтааж буй нь алтны салбар гэдгийг бүгд хүлээн зөвшөөрдөг. Зарим судалгааны дүнгээс харахад оргил үедээ алтны салбарт 100 мянга орчим монголчууд хувиараа ашигт малтмалыг улирлын чанартай олборлож байсан байдаг. Бусад ашигт малтмалыг бодвол алтны үнэ харьцангуй өндөр, худалдан борлуулахад хялбар, үндсэн болон шороон ордыг аль алийг нь ашиглах боломжтой нөхцөл нь тэднийг татдаг байна.

Дэлхийн жишигт хэрэв тухайн улсын эдийн засаг, төсөв, экспорт зэрэг макро хүчин зүйлүүдэд уул уурхайн эзлэх жин хэмжээ тус, тус 10 хувиас дээш байвал “уул уурхайн үндэстэн” буюу “mining nation” гэж үздэг. Манай хувьд ДНБ-ий 20-30 хувь, төсвийн 30 хувь, экспортын 90 хувь, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 70 хувийг уул уурхай дангаараа эзэлж байгаа юм. Амьжиргааны гол эх үүсвэрээ хувиараа ашигт малтмал олборлолтоос буй болгодог нийгмийн томоохон хэсэг ялангуяа зах зээл сул хөгжсөн хөдөө орон нутагт бий болсон нь дагаад нийгэм-соёл, байгаль орчин, эдийн засгийн нөлөөллийг бүх түвшинд үзүүлэх болсон. Иймээс хожим ч гэсэн төрийн бодлогод тусах болж 2010 оны долдугаар сард Ашигт малтмалын тухай хуульд бичил уурхайг хүлээн зөвшөөрснөөр Засгийн газрын 308 тогтоолоор Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмыг баталжээ. Хууль бус алт олборлогчоос хууль ёсны бичил уурхайчин болох эрх зүйн энэ боломж нь тэдгээр хүмүүст нөхөрлөл, хоршоо байгуулах замаар хамтын зохион байгуулалтад орох, амьжиргааны эх үүсвэрээ баталгаажуулж хууль ёсны болгох, хүний эрх, эрүүд мэндээ хамгаалуулах, нийгмийн үйлчилгээ авах, татвар төлөгч болох зэрэг өргөн боломжуудыг нээж өгсөн. Нөгөө талаас төр бичил уурхайчидтай гэрээ хийснээр иргэдээ бүртгэх, ажлын байраар хангах, байгаль орчныг нөхөн сэргээх, хамгийн гол нь далд байсан алтны худалдааны орлогыг ил болгож татвар авч Монголбанкны алтны нөөц



ЗГМ ©

нэмэгдэх болсон байна.

Цаашид ч бичил уурхайчдын олборлолтыг ил тод болгож, алтны нийлүүлэлтийн сүлжээг албажуулснаар цаашид тогтмол өсөн нэмэгдэх бүрэн нөөц боломж бий. Монголын уул уурхайн салбарын үндсэн харилцаанууд Ашигт малтмалын тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль гэсэн цөөхөн хэдэн хуулиар зохицуулагдаж байлаа. Эдгээр хууль нь лиценз, татвар, роялтийн асуудлыг голчлон зохицуулдаг. Гэтэл уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа, худалдаа, тээвэр, экспорт, худалдааны сүлжээ гэх зэрэг “далд бүтэц”-ийн асуудал тодорхой бус, зохицуулалт, томьёолол муу хэвээр.

● Бичил уурхайчдын нөхөрлөлүүдийн тоо тогтмол өсөж, Монголбанк дахь алт тушаалтын хэмжээ өсөж байгаа хэдий ч энэ нь бичил уурхайн нийлүүлэлтийн сүлжээ бүрэн ажиллаж байгаа гэсэн үг биш юм.

● Хамгийн хорлонтой нь 68 хувийн татвар байхгүй болсон ч гэсэн өнөөг хүртэл хууль бус олборлолт болон алтны далд худалдаа бүрмөсөн алга болохгүй байгаа юм.

● Бичил уурхайчдын орлого 20 орчим хувиар нэмэгдсэнээр дагалдаж орон нутагт худалдаа, үйлчилгээний үйл ажиллагаа сайжирч улмаар худалдан авалт нэмэгдэх, орон нутгийн төсөвт тодорхой хэмжээний төлбөр, хураамжийн хэмжээ нэмэгдэнэ.

Оролцогч талууд (лиценз эзэмшигч, зохицуулагч агентлагууд, орон нутаг, хил гааль, татвар, мэргэжлийн хяналт, иргэдийн оролцоо)-ын эрхзүйн статус тодорхой бус дээр нь үйлдвэрлэгч ба худалдан авагч зах зээл хоёрыг холбосон дэд бүтэц (бирж, лаборатори, дундын зуучлагч, эрх бүхий тээвэрлэгч) сул хөгжсөний дээр эдгээрийн хооронд үүсэх

эрхзүйн харилцаа, эрх үүргийн хэм хэмжээг одоо бүр тодорхой болгоогүй байгаа юм гэх үндэстэй. Нэг хэсэг худалдааны тухай болон эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай гэх зэрэг хуулиар зохицуулна гэж төлөвлөн хуулиудын төсөл боловсрох байсан. Гэвч сүүлийнх нь одоо хүртэл батлагдаагүй шийдлээ хүлээж байна.

Хамгийн чухал нь алтны нийлүүлэлтийн сүлжээг албажуулж бүртгэлжүүлснээр олборлосон ашигт малтмалаас улс төдийгүй орон нутаг ашиг хүртэж нийт иргэдэд баялгийг шударгаар хуваарилах нэг зөв хувилбар харагдаад байна. Төр бодлогын хувьд алтны худалдаачдыг шууд үгүйсгэж хатуу хориглож эхэлбэл улам нууц, улам хөнөөлтэй байдалд шилжих эрсдэл бодитоор тулгараад байна. Эрхзүйн зохицуулалт бүдэг бадаг бөгөөд дээр нь хэт чангалсан хууль гарснаас өнөө зохицуулах гээд байгаа асуудлаасаа илүү олон хор дагавар үүсдэг. Жишээ нь мафиин алтан үеийг цэцэглүүлсэн Америкийн алдарт хуурай хууль байна.

Хэдийгээр бичил уурхайчдын нөхөрлөлүүдийн тоо тогтмол өсөж, Монголбанк дахь алт тушаалтын хэмжээ өсөж байгаа хэдий ч энэ нь бичил уурхайн нийлүүлэлтийн сүлжээ бүрэн ажиллаж байгаа гэсэн үг биш юм. Юуны өмнө ашигт малтмалын талаарх төрийн бодлого тогтворгүй байж үргэлж өөрчлөгдөж байдгаас алтны нийлүүлэлтийн сүлжээ ил, далд хэлбэртэй болжээ. Ялангуяа дэлхийн зэх зээл дээр алтны үнэ өсөж байсан 2010 онд урт нэртэй хууль батлагдсан, 68 хувийн татвар бий болсноор бичил уурхайчдын алтны олборлолт, тушаалт эрс багассан төдийгүй алтны сүлжээ хууль бус далд хэлбэрт орсноор үлэмж хэмжээний хохирол бий болсон юм. Татварын хэт өндөр босготой тулсан жижиг дунд олон компаниуд татвараас зугтах, өндөр хүүтэй зээлсэн техник технологийн зээлээ төлөх гол арга нь техникжсэн нинжа болж хувирсан олон жишээ бий. Тэд өндөр татвар төлж дампуурахын оронд хүч чадалтай сайн техникээр алтны бага нөөцтэй газруудыг орчлон хулгайгаар ухаж олсон алтаа хууль бус татваргүй сүлжээгээр дамжуулан борлуулах явдал болж хувирсан байдаг. Энэ тухай нийтлэлч Баабарын нийтлэлд

“Жаран найм” гараад ирэнгүүт хэн ч алтаа Монголбанкинд тушаахаа болив. Ингээд гэмт хэргийн сүлжээ үүслээ. Алт олборлогчдын хувьд найдвартай, хавьгүй бага татвартай, элдэв хулхи байхгүй, гар хийцийн боловч завод тэрэгнээс дутахгүй жинхэнэ “жаран найм” машин! Эхэндээ ч жаахан болхи байсан л даа. Алтан бүстэй, гинжтэй, бугуйвчтай, оосортой “алтан хүн” Замын-Үүдийн боомтоор өдөрт 10 удаа нааш цааш гарна. Хилийн цаана бэлэн юаньтай, шалгах бүх төхөөрөмжтэй хятад наймаачид хүлээж байна. Явсаар төгөлдөржин том, жижиг компаниуд бүгд алтаа ченжид тушаадаг болов” хэмээн оновчтой тодорхойлсон байдаг.

Хамгийн хорлонтой нь 68 хувийн татвар байхгүй болсон ч гэсэн өнөөг хүртэл хууль бус олборлолт болон алтны далд худалдаа бүрмөсөн алга болохгүй байгаа юм. Дэлхийн зах зээлд тухайн ашигт малтмалын үнэ өндөр байхад төрийн бодлогын алдаанаас шалтгаалж хангалттай ашиглаж өндөр орлого олж чадахгүй байгаа бидний нийтлэг алдаа алтан дээр гарч байсан бол өнөөдөр нүүрсэн дээр ч гарч байгааг энд заавал дурдах ёстой. Нэгэнт бий болчихсон энэ алтны хууль бус сүлжээ нь бичил уурхайчдын хувьд тухайн өдөртөө олборлосон алтаа хадгалахад хэтэрхий эрсдэлтэй байдаг, Монголбанкинд тушаахын тулд заавал Улаанбаатар хот уруу ирж тушаах хэрэгтэй болж байгаа дэд бүтцийн хүндрэлийг гаргагдаггүйгээрээ илүү уян хатан, илүү өгөөжтэй байгаа учраас далд сүлжээг илүү сонирхох сэдлийг төрүүлж байна. Алтны энэ хууль бус далд хэлбэрийн үндсэн сүлжээ нь бичил уурхайчид өдөрт олборлосон алтаа уурхайн аман дээр байдаг эсвэл сумын төвд байрлаж байдаг зуучлагчдад ихэвчлэн борлуулж тэдгээр зуучлагчид нь дунд шатны буюу аймгийн төв, хотоос яваа явуулын дунд гарын зуучлагчдад алтаа тушаадаг байна. Дунд гарын зуучлагчид авсан алтаа сорьц, чанарыг тогтоолгосноор Монголбанкинд тушаах эсвэл үнэт эдлэл хийдэг хүмүүст өгөх, Монгол дахь гадаадын алтны инд шатны нууцлаг ченжүүдэд борлуулдаг ажээ. Ядаж байхад Монголын зах зээлд эргэлдэж байгаа алт үнэт эдлэлийн хэмжээ, үнийн судалгаа, бүртгэл байдаггүйгээс ээмэг бөгж,

бугуйвч, зүүлт хэлбэрээр иргэдийн хувийн эдлэл мэтээр өдөрт ямар их татваргүй алт гарч байгааг бас үнэлэх боломжгүй байна.

Алтны энэ далд сүлжээ нь бичил уурхайчдаас орон нутгийн алтны зуучлагчид нь алтныг Монголбанкнаас зарласан тухайн өдрийн үнээс 10-15 хувиар бага үнээр авдаг төдийгүй бичил уурхайчдын мэдлэггүй, мэдээлэлгүй байдлыг далимдуулан баталгаажуулахгүй жин хэмжүүр ашиглах, лан, цэн зэрэг уламжлалт нэгжээр үнэлж мөнгийг нь дутуу төлөх, урьдчилан өндөр хүүтэй зээлийг бэлэн мөнгө болон бараа бүтээгдэхүүнээр олгож өрийн сүлжээ үүсгэх зэрэг цэвэр мөнгө хүүлэлтийн механизм бий болгож байгаа юм. Ер нь аль 200 жилийн өмнөөс хятад худалдаачдаас үүсэлтэй мөнгө хүүлэлтийн энэ систем нь зөвхөн алт биш хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, мах, өргөн хэрэглээний бараан дээр ч үүсэн бөгөөд ченжүүдийн энэ давхарга нь ашгийн ихэнх хувийг хүртэж анхны үйлдвэрлэгчид хамгийн багийг хүртдэг ашиггүй систем юм.

Шууд үгүйсгэж хатуу хориглож эхэлбэл улам хөнөөлтэй

Төр энэ ченжийн нийлүүлэлтийн системийн эсрэг нийлүүлэлтийн дэд бүтцийг буй болгох ёстой ч хангалттай биш байгаа нь алтны салбарт ч тод байна. Орон нутагт Монголбанкны болон Сорьцын хяналтын газрын үйлчилгээг алтны бичил уурхайчид авах боломжгүй байгаа нь ченжийн систем амь бөхтэй орших үндсэн шалтгаан болж байна. Монголбанкны салбар бүх аймгуудад байхгүйн дээр орон нутаг дахь арав гаруй салбар хэлтэс нь алт худалдан авах, хадгалах үйл ажиллагаа явуулахгүй байгаагаас бичил уурхайчдын хувьд алтаа тушаахад хүндрэл учирч байгаа гэсэн үг юм.

Мөн орон нутагт сорьцын лаборатори байдаггүйгээс тухайн байцаагч алтны талаар мэдээлэл бичиж суух үүрэгтэй төдий ажиллаж байгаа юм. Нийлүүлэлтийн дэд бүтцийн үйлчилгээг төр хийж чадахгүй

байгаагийн улмаас бичил уурхайчид нь олборлосон алтныхаа 95 хувийг зуучлагчид газар дээр нь борлуулахад хүргэж байгаа аж. Монголын экспортлогчдын холбооны 2014 онд хийсэн судалгааны зөвлөмжөөс харахад алтны хүдэр баяжуулах үйлдвэр, бичил уурхай төвлөрсөн аймаг, сумдыг түшиглэн Монголбанк, Стандарт, хэмжилзүйн газар хамтран алтыг сорьцоох үйлчилгээ болон алт худалдан авах банкны салбарыг бий болгож алтны худалдааны нэг цэгийн үйлчилгээг төр яаралтай зохион байгуулах шаардлагатай байгаа юм. Дээр нь нэгэнт үүссэн энэ давхаргын зуучлагчдыг ч давхар бүртгэж алт худалдан авах нэг цэгийн үйлчилгээ бий болгож албажуулах шаардлага бий.

Уул уурхайгаас ашиг хүртэгч улстөрчид, төрийн шийдвэр гаргагчдыг тодорхой болгох хууль эрх зүйн орчныг шинэчлэх ажил дундын шиг хүртэгчидтэй тэмцэх, ил тод уурхайг хөгжүүлэх ажлын салшгүй нэг хэсэг байх ёстой. Учир нь ашиг хүртэгч эздийн мэдээлэл дутуу байгаагаас тэдгээр хууль бус олборлолтоос олсон орлого нь аль салбарт шилжиж орою болж байгаа, төрийн түшмэдийн халаасыг хэрхэн дүүргэж буй нь тодорхойгүй байна. Олон улсын туршлагаас харахад Монголд алт худалдаалах хууль бус сүлжээгээр олсон тэр олон сая доллар нь зах зээлд барилга орон сууцны зах зээл, үл хөдлөх хөрөнгө, үйлчилгээний газрууд, газар өмчлөх зэрэг хэлбэрүүдэд шилждэг санхүүгийн сүлжээ үүссэн байх магадлалтай билээ. Үлстөрчид дундаршгүй мөртлөө тайлбарлаж чадаагүй их орлого чухам энэ сүлжээ-нээ л тэтгэгдэж байх ёстой. Тиймээс уул уурхайгаас ашиг хүртэгч жинхэнэ эздийг нарийн тодорхойлсон хууль эрх зүйн зохицуулалтыг яаралтай гаргах нь улс төрийн манлайлал байх болно гэдгийг улс төрчид анхаарах ёстой хэмээн хүсэж байна.

Алтны нийлүүлэлтийн сүлжээг албан болгож бүртгэлжүүлснээр бичил уурхайчдад ирэх бас нэгэн өгөөж нь тэдний орлого нэмэгдсэнээр тэд өөрсдийн орлогын зохих хэсгийг орон нутагт шинэ ажлын байр бий болгох, зөвхөн бичил уурхайн орлогоос хамааралтай биш бусад орлогын эх үүсвэртэй болох, мэргэжил эзэмших, оюутан хүүхдийн сургалтын төлбөрийг төлөх гол зорилготой улирлын бичил уурхайчид эрс багасах, уламжлалт аж ахуйгаа өөд татах боломжтой болох юм. Бичил уурхайчдын орлого 20 орчим хувиар нэмэгдсэнээр дагалдаж орон нутагт худалдаа, үйлчилгээний үйл ажиллагаа сайжирч улмаар худалдан авалт нэмэгдэх, орон нутгийн төсөвт тодорхой хэмжээний төлбөр, хураамжийн хэмжээ нэмэгдэх юм.

Ирээдүйд Монголын алтны зах зээл үндсэн болон бусад металлын ордуудыг ашигласнаар 1.5-2 дахин нэмэгдэнэ. Тэр үед илүү их орлоготой эрүүд ил тод, бүртгэлжсэн бичил уурхайчидтай болох уу бүр олон нинжатай болох уу гэдгийг өнөөдөр л тодорхойлно. Шийдвэр гаргагчдад сануулахад алтны нийлүүлэлтийн сүлжээний хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, Монголын алтыг Монголдоо үлдэх үндсэн арга бол бид өөрсдөө алт цэвэршүүлэх үйлдвэртэй болох ёстой. Ийм үйлдвэрийг алтны сүлжээгээр хангах сүлжээг тэр цагт бид хүссэн ч хүсээгүй ч хийх л болно.

НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙРНЫ ЗАР

БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР:

АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Сурталчилгаа, борлуулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр байнгын харилцагчдын хүрээллийг тогтмол тэлэх, санаачилга гаргах, гэрээ хэлэлцээр хийх, албан бичиг боловсруулах, танилцуулах чадвартай байх
- Борлуулалтын хэлцэл хийх, уулзалт зохион байгуулж, танилцуулга бэлтгэх, танилцуулах
- Байгууллагаас захиалсан сурталчилгааг хүлээн авах, хянах, эцсийн байдлаар хүлээлгэн өгөх
- Байгууллагын бусад ажилтнуудтай хамтран ажиллах

АЖИЛ ГОРИЛОГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Цаг үеийн өөрчлөлтийг мэдэрч, шинэ санаачилга гаргах, үүнийг хэрэгжүүлэх, хянах, тайлагнах чадвартай байх
- Шинийг санаачлагч, багаар ажиллах чадвартай, тогтвор суурьшилтай ажиллах эрмэлзэлтэй байх
- Уул уурхайн салбарт мэргэжлээрээ ажиллаж байсан бол давуу тал болно
- Төлөвлөлт болон бэлтгэл ажлыг оновчтой хийдэг байх
- Англи хэлний өндөр мэдлэгтэй байх ба хятад эсвэл орос хэлийг хоёрдогч хэлээ болгон эзэмшсэн бол давуу тал болно
- Холбогдох чиглэлээр мэргэжил эзэмшсэн, эсвэл ажлын туршлагатай байх

Хэрэв та өөрийгөө дээрх ажлын байранд нийцэх боловсон хүчин гэж үзэж байгаа бол англи эсвэл Монгол хэлээр бэлтгэсэн танилцуулгаа доорх хаягаар илгээгээрэй. Бид тантай холбогдож, дараагийн алхмуудыг хэлэлцэх болно.

ХОЛБОО БАРИХ:
9913 5112

info@asiamining.mn
хаягаар холбоо барина уу.

Нийгэм

Монголчууд 100 тэрбум төгрөгийг тамхинд зарцуулдаг

Жилд дунджаар 100 тэрбум төгрөгөөр тамхи худалдан авч байна

Тодруулбал, тамхины цэг байгуулах төсөлд нийслэлээс хөрөнгө мөнгө төсөвлөж, автобусны буудал бүрт өндөр өртгөөр шилэн цэг байгуулсан ч үр дүнд хүрээгүй. Мөн Тамхины онцгой албан татварыг нэг хувь байсныг хоёр болгож нэмэгдүүлсэн ч иргэдийн худалдан авалт буураагүй төдийгүй тамхинаас шалтгаалсан өвчлөл нэмэгдсэн байна. Тиймээс тамхи үйлдвэрлэгчдийг хянах тогтолцоог бүрдүүлэх хэрэгтэй байгааг эмч нар сануулж байна.



С.Батсайхан / ЗГМ©

тус нэмэгдэнэ гэж тооцоолжээ. Улмаар жижиглэнгийн үнэ дунджаар 300 төгрөгөөр нэмэгдэх юм.

ХОЁР ХУВИЙН ТАТВАР БУСАД ОРОНТОЙ ХАРЬЦУУЛАХАД МАШ БАГА

Монгол Улс тамхинаас хоёр хувийн онцгой албан татвар авч байна. Тооцоолж үзвэл нэг ширхэг тамхинаас 38.4 төгрөг, 100 ширхэг тамхинаас 3480 төгрөг авч байна. Энэ нь бусад оронтой харьцуулахад маш бага үзүүлэлт юм. Жишээлбэл, Украин улсад тамхины худалдах үнийг 50 хувь хүртэл нэмэгдүүлэхэд тамхи татагчдын тоо 500 хүртэл мянгаар буурч, 253 хүний амь нас аврагдаж, жилд төсөвтөө 281 сая ам.доллар төвлөрүүлж чадсан сайн жишиг байна.

Мөн ОХУ тамхины онцгой албан татвар нэмэх шийдвэр гаргаснаар 80 мянган хүнийг зүрх судас, уушигны хорт хавдраар өвчлөхөөс нь өмнө урьдчилан сэргийлж чадсан. ОХУ цаашид тамхи худалдах үнийг 70 хүртэл хувиар нэмэгдүүлснээр 2.7 сая хүнийг тамхинаас бүрмөсөн гаргаж, онцгой албан татварт жилд зургаан тэрбум ам.доллар төвлөрүүлэх боломжтой хэмээн үзэж байгаа аж. Тэгвэл Монгол Улсад сүүлийн 10 орчим жилийн хугацаанд янжуур тамхины үйлдвэрлэл дөрөв дахин нэмэгдэж, импорт 2.5 дахин өссөн үзүүлэлтээс харахад Тамхины хяналтын тухай хууль хэрхэн хэрэгжиж, ямар үр дүн үзүүлж байгааг тодхон харж байна.

Гаднын орнуудад Тамхины хяналтын тухай хууль, албан татварын хэмжээг нэмэгдүүлэх бодлого бодит ажил болж, өгөөжөө өгч байхад Монголд нөхцөл байдал эсрэгээрээ байгааг эрүүл мэндийн салбарынхан хэлж байна. Иргэдийн дунд тамхины хэрэглээ буурах биш өсөх, ялангуяа өсвөр үе, хүүхэд залуучууд хорт утааг хэрэглэх хандлага ажиглагдах болсныг эмч нар дуулгав.

Уг нь олон нийтийн газар, үйлчилгээний төвд тамхи татахыг хориглосноор тамхины хэрэглээ нэг үеэ бодвол буурсан. Энэ бол Тамхины хяналтын тухай хууль хэрэгжиж эхэлснээр бодит үр дүнд хүргэсэн сайн жишээ. Гэсэн ч хэрэглээнд илүү анхаарал хандуулах хэрэгтэй байгаа аж. Иймд ирэх оноос Тамхины онцгой албан татварын хэмжээ нэмэгдвэл иргэдийг эдийн засгийн болоод эрүүл мэндийн алдагдлаас сэргийлэх боломж бүрдэх юм. [ЗГМ]

Нийслэлтэй хатуу хучилттай замаар холбогдсоноос хойш иргэд авто тээврийн үйлчилгээг сонгосноор өвлийн агаарын тээврийн үйлчилгээ сүүлийн жилүүдэд зогсоод байгаа. Тэгвэл энэ сарын 24-нөөс "Аэро Монголиа" компанийн roker-50 онгоц Улаанбаатар-Мөрөн-Улаанбаатар чиглэлд тогтмол нислэг үйлдэхээр болжээ. Нислэгийн тасалбарын үнэ 99 мянган төгрөг бөгөөд ням гараг бүрт нислэг үйлдэгдэхээр тогтсон байна.

» ДОРНОГОВЬ

Нэгдсэн эмнэлэг хог хаягдлыг хадгалах, устгах байгууламжтай болов. Барилгын ажлыг энэ оны зургадугаар сараас эхлэн "Зорь-Бүтээ" ХХК улсын төсвийн 142 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар барьж арваннэгдүгээр сард хүлээлгэн өгчээ. Эмнэлгийн хог хаягдлыг хадгалах, устгах байгууламж нь тус аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй эмнэлгүүдийн аюултай хог хаягдлыг хүлээн авч ангиалан, халдваргүйжүүлж устгах боломжтой болсон байна.

» БАЯНХОНГОР

Төрийн өндөр албан тушаалтан, шүүгч, прокуророос бусад бүх албан хаагчдад энэ долоо хоногдоо 300 мянган төгрөг олгохоор болжээ. Аймгийн хэмжээнд 3851 төрийн албан хаагч байдаг аж. Гэхдээ төрийн өндөр албан тушаалтнуудаас бусад албан хаагчдад 300 мянган төгрөг шилжүүлэх юм. Тус урамшууллыг төрийн албан хаагчид цалин олгодог журмаар тооцох бөгөөд Хувь хүний орлогын албан татвар болон нийгмийн даатгалын шимтгэл суутгаж авна. Урамшуулал хэлбэрээр олгож байгаа ч Хөдөлмөрийн тухай хуульд үндсэн болон нэмэгдэл цалин, урамшуулал, шагналын мөнгөнөөс шимтгэл төлнө гэж заасан учир шимтгэл авч байгаа албаныхан тайлбарлав.

ЗГМ: ИНФОГРАФИК

ТАМХИНЫ ХЭРЭГЛЭЭ



ЖИЛ БҮР
5.4
САЯ ХҮН НАС БАРЖ
БАЙНА



2030 ОНД
8.3
САЯД ХҮРНЭ



НАСАНД ХҮРСЭН ХҮН АМЫН
27.1%



ЕБС-ИЙН 11-17 НАСНЫХНЫ
9.2%

ТАМХИ
ТАТДАГ

ХҮН АМЫН ӨВЧЛӨЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААНЫ НЭГ БОЛЖ БАЙНА:



АМЬСГАЛЫН
ТОГТОЛЦООНЫ
ӨВЧЛӨЛ



ЗҮРХ СУДАСНЫ
ӨВЧЛӨЛ



УЛААН ХООЛОЙ
БОЛОН УУШГИНЫ
ХОРТ ХАВДАР

НАС БАРАЛТ:



ЗҮРХ СУДАСНЫ
ЭМГЭГ



ХОРТ ХАВДРЫН
УЛМААС

ОХУ	31.6
ЭНЭТХЭГ	33.1
БНХАУ	47.6
ТУРК	73.3

НЭГ ХАЙРЦАГ ТАМХИНД
НОГДОХ ТАТВАРЫН
ХЭМЖЭЭ: (ХУВЬ)



БРАЗИЛ	61.4
ПОЛЬШ	84.3
МОНГОЛ	25

ДЭМБ, Сангийн яам©

ЗГМ: ТОДРУУЛГА

Монгол руу чиглэсэн олон улсын санхүүжилт буурч байна

“Дэлхийн зөн” хүн амын гуравны нэгд нь хүрч ажилладаг

Б.Баярмаа
@bayarmaaZGM

“Дэлхийн зөн Монгол” олон улсын байгууллагын үйл ажиллагааг харуулсан захирал Дорно Хавиараас Монгол Улсын ядуурлын өнөөгийн нөхцөл байдлын талаар байр суурийг нь сонслоо.

–Монгол Улсын эдийн засгийн үзүүлэлт өсөж байна. Гэвч эдийн засгийн өсөлтийг дагаад буурах ёстой ядуурлын хэмжээ эсрэгээрээ нэмэгдлээ. Үүний гол шалтгаан юу вэ?

–Дөрвөн жилийн өмнө Монголд ирэхэд ам.долларын ханш 1800 төгрөгтэй тэнцэж байсан. Харин



С.Батсайхан / ЗГМ©

одоо бараг 50 хувиар өссөн байна. Инфляц нэмэгдсэнээр төгрөгийн худалдан авах чадвар буурсан. Ядуурлын түвшнээс дээш амьдралтай байсан хүмүүсийн амьжиргаа муудаж, ядуучуудын тоонд багтсан нь хамгийн гол шалтгаан юм.

–Ядуурлыг бууруулахын тулд нэн түрүүнд ямар арга хэмжээ авах ёстой вэ?

–Орлого нь өсөж буй уул уурхайн салбарынхан хөдөлмөрийн насны хүн амд эзлэх хувь нь тун бага. Тиймээс эдийн засаг болон

орлогын эх үүсвэрээ төрөлжүүлэх хэрэгтэй. Ингэснээр иргэд хувийн бизнес эрхлэх боломж бүрдэнэ.

“Дэлхийн зөн” Монгол Улсын хүн амын бараг гуравны нэгд нь хүрч ажилладаг. Тусламж нэн шаардлагатай байгаа, эрсдэлтэй нөхцөлд амьдарч буй хүнийг олох нь хамгийн бэрхшээлтэй асуудал болдог. Ядуу гэж хэнийг хэлэх вэ, тэдэнд ямар хэрэгцээ, шаардлага байгааг нарийн судлах хэрэгтэй.

Дараа нь хөтөлбөрөө Монголд хэрхэн нутагшуулах вэ гэдгийг судалдаг. Мөн үйл ажиллагааныхаа

үр дүнг тооцож, хэмжих нь чухал.

–“Дэлхийн зөн Монгол” байгууллага манай улсад 20 гаруй жил үйл ажиллагаа явуулжээ. Энэ хугацаанд хамгийн хүнд саад нь юу байсан бэ?

–Монголын газар нутаг өргөн уудам, хэт тархуу. Нэг айлаас нөгөөд очих гэж 40-50 км явдаг тул бусад орныг бодвол үйл ажиллагааны зардал маш их гардаг. Анх “Дэлхийн зөн”-г санхүүжилт сайтай, баян байгууллага гэж хардаг байсан. Монголын эдийн засаг сайжирч, харьцангуй хурдтай хөгжиж байгаа орон гэж олон улсад хардаг болсон учраас сүүлийн жилүүдэд олон улсаас ирдэг санхүүжилтийн хэмжээ буурч байгаа. Гэтэл бодит байдал тийм биш. Ядуурал улам нэмэгдэж, нэн эмзэг амьдралтай хүний тоо олширлоо.

–Танай байгууллага онгөрсөн хугацаанд хийсэн ажлаа хэрхэн дүгнэж байна вэ?

–Орон нутаг дахь хүүхдүүдийн эрүүл, хүчирхийллээс ангид орчинд амьдрах боломжийг сайж-

руулж, боловсролтой болгох нь бидний гол зорилго. Манай байгууллага одоогийн байдлаар 15 аймаг болон нийслэлийн долоон дүүрэгт үйл ажиллагаа явуулж байна. 2000 оны эхээр монгол хүүхдүүд тэжээлийн дутагдал орж, үнэхээр хүнд байсан. Үүнд чиглэсэн 5-10 жилийн хугацаатай олон төсөл хэрэгжүүлсний дүнд өнөөдөр нөхцөл, байдал эрс сайжирлаа. Мөн 11-ээс доош насны хүүхдүүдийг сургууль, цэцэрлэгт ямар нэг байдлаар хамрагдахад хүч хаяж ажилласан.

–Цаашид ямар чиглэлд түлхүү анхаарах вэ?

–“Дэлхийн зөн” Монгол дахь үйл ажиллагаагаа зогсоолоо гэхэд бидний хүрч ажилласан хүмүүс сайхан амьдрах боломжтой байх хэрэгтэй. Өөрсдөө талхаа хийх, байшингаа барих, сайхан амьдрах орчноо бий болгох чадвар суулгахыг ирэх хэдэн жилд зорьж байна. Хамгийн гол нь ядуурлаас гарах ёстой гэдгийг ойлгуулж, сэтгэлгээг нь өөрчлөхөд анхаарлаа хандуулна. [ЗГМ]

ZGM DAILY

IMF completes first and second review of EFF program

Completion of the review enables Mongolia to draw about USD 79.1 million.

Mongolian athletes win 4 medals from IJF Masters

Sumiya Dorjsuren and Kherlen Ganbold become champions in their weight category.

Fuel imports grew by USD 227.1 million

According to National Statistics Office, abundant reserves of fuel has been stocked.

Ban on Tavan Tolgoi coal transport takes effect

Coal truck jam in Gashuunsukhait border check-point reduced to around 70 km.

ZGM: HIGHLIGHTS

POLITICS

Khurts Bat has been appointed as the Ambassador of Mongolia to the Republic of Korea.

Ambassador of Mongolia to the Republic of Macedonia Batsaikhan Dashjants pays a courtesy call on Macedonian Minister of Foreign Affairs Nikola Dimitrov.

Batzorig Batjargal, Minister of Food, Agriculture and Light Industry, paid an official visit to Russian Federation to meet his Russian counterpart.

ECONOMY

MSE ALL Index decreased by 0.9 percent to stand at 1,166.71 points. APU JSC's stock price fell by 2.66 percent, reaching MNT 717.54 on Friday.

'Investor Nation' Closed Joint Stock Company merged with MSE listed 'Jinst Uvs' JSC, hence becoming a public company.

At the request of the Parliament's Standing Committee on Economy, the Development Bank will be audited soon.

Coal truck jam in Gashuunsukhait reduced to around 70km after the related minister's decision to halt transportation from Tavan Tolgoi deposits.

SOCIETY

Shijirbat.B claimed the fourth place in the Asia's Got Talent show.

Mandal soum goes under quarantine due to animal disease. Accordingly, both vehicle and train traffic have been restricted in the area.

On the occasion of the 45th anniversary of the Philosophy Department of Mongolian Academy of Sciences, a research conference under the theme "Mongolian Social Development Philosophy and Policy" took place.

43 Mongolian physicians and specialists to participate in professional development trainings in seven fields.

IMF approves USD 79.1 million disbursement

IMF advices to maintain strong commitment to the program

Tugsbilig.B
@tugsbiligZGM

The Executive Board of the International Monetary Fund (IMF) completed the first and second reviews of Mongolia's performance under the program supported by a three-year extended arrangement under the Extended Fund Facility (EFF) on December 15. IMF reported that Mongolia's economy is recovering with GDP growth projected to be better than expected and all quantitative targets under the program have been met.

Completion of the review enables Mongolia to draw about USD 79.1 million, bringing total disbursements under the arrangement to SDR 83.868 million (about USD 118.6 million).

According to IMF, the economic growth in 2017 is projected to reach 3.3 percent, considerably better than forecasted at the time of program approval. The combination of strong policy implementation and a supportive external environment has helped the authorities over-perform on all of the quantitative targets under the program. Performance on structural reforms has also been



Total disbursements under the arrangement totals SDR 83.868 million (USD 118.6 million).

BBM©

strong, notwithstanding the delays due to the change in government in September.

Following the Executive Board's discussion of the review, Mitsuhiro Furusawa, Acting Chair and Deputy Managing Director, said, "All quantitative targets under the program have been met. Fiscal results have been better than expected, sup-

ported by stronger revenues and tight expenditure control, and the fiscal deficit this year, at 7.6 percent of GDP, is less than half of what it was in 2016. The recently approved 2017 Supplementary Budget and the 2018 Budget are in line with the program. About half of the revenue overperformance will be saved, thus helping to reduce borrowing and control


debt, while the remainder will be used to fund productive spending in line with the government action plan and for a one-off bonus to civil servants. Net international reserves have improved, reflecting strong coal export performance, capital inflows into the bond and money markets, and donor disbursements."

"With debt still high and the


economy still exposed to global commodity developments, it is critical to maintain strong commitment to the program. Sustained implementation of the reform agenda, will help cement solid growth, improve confidence, strengthen fiscal revenues and foreign reserves, and mobilize donor support," advised the IMF. [ZGM]

FX MARKET


USD/MNT rate (Two months to date)



EUR/MNT (Two months to date)



CNY/MNT rate (Two months to date)



Bank of Mongolia©

SPORTS

Sumiya Dorjsuren: the first four-time IJF Masters Champion



Masters St Petersburg 2017, the last destination of International Judo Federation's World Judo Tour, concluded on Sunday. Mongolian World champion Sumiya Dorjsuren, a three-time World Judo Masters winner, won her fourth consecutive masters and became the first athlete to be titled IJF World Masters Champion. Alongside her, Mongolian athletes grabbed another 1 gold and 2 silver medals from the tournament. Specifically, the 26-year-old athlete had two of her toughest rivals in St. Petersburg with Tokyo Grand Slam winner Tsukasa Yoshida and Olympic champion Rafaela Silva and came out victorious in the U57 kg category, while Urantsetseg Munkhbat secured third place in women's U48 kg for the bronze. As for the men's competition, Kherlen Ganbold brought down Asian Champion Yeldos Zhumanakov for the gold in the U66 kg weight range and Amartuvshin Dashdavaa won bronze in the U60 kg.

The World Judo Masters is one of the premier showcases of judo with the stars of the circuit in action including Olympic and world champions. It was announced that 214 judoka (109 men and 105 women) from 46 nations have participated in the masters. [ZGM]

COMMODITY

NSO: Fuel imports increased by 32.2 percent

National Statistics Office informed that the fuel import grew by USD 227.1 million in the first 11 months of 2017, a 32.2 percent increase. Diesel imports rose to USD 385.5 million, showing 75.8 percent increase.

With the restoration of coal industry, the transportations increased and economy also recovered. On the other hand, the excise tax on



gasoline, which was previously excluded, has gradually increased in accordance to the implementation of International Monetary Fund's program. The industry experts explain that the domestic demand was high due to the above-mentioned reasons. According to the Mineral Resources and Petroleum Authority, abundant amount of fuel was reserved in October and November. [ZGM]

TRANSPORTATION

Air transport revenue

299.6 billion MNT
▲11.7%



Rail transport revenue

481.8 billion MNT
▲18.6%



Air freight transport
2.8 million tons
▼2.1%



Air transportations carried
761.7 thousand passengers
▲22.5%



Rail freight transports
299.6 million tons
▲13.6%



Rail transportations carried
299.6 million passengers
▼0.2%

nso.mn©

Лавлах

ЭКОЛОГИ Нас бие гүйцсэн 34 ирвэс байгааг ТОГТООВ

Б.Бямба
ЗГМ

Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газрын мэргэжилтнүүд цоохор ирвэс судлах ажлыг эрчимтэй хийж байна. Тэд автомат камер тавих, ирвэсэнд сансрын дохиололтой хүзүүвч зүүх зэргээр шилжилт хөдөлгөөнийг нь судалж байгаа аж. Түүнчлэн гаднынхантай хамтран цоохор ирвэсийн генетикийн судалгааг хийж байна. Энэ ажлын хүрээнд Алтай, Соёоны бүс нутаг дахь Баатархайрхан уулын ирвэсийн тоо толгойг тогтоохоор нэг жилийн өмнө 68 ширхэг автомат камер тавьжээ. Камерт бичигдсэн ирвэсийг толбоор нь тодорхойлоход Баатархайрхан ууланд нас бие гүйцсэн 34 ирвэс, найман гүем байгааг тогтоожээ. [ЗГМ]

ХЯНАЛТ ШАЛГАЛТ Хаяг шошгын зөрчилтэй бүтээгдэхүүн илрүүлжээ

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газраас шинэ жил болох гэж буйтай холбогдуулан есөн дүүрэгт хяналт шалгалт явуулжээ. Шалгалтаар 422 зөрчил илрүүлсний дийлэнхийг нь хадгалах хугацаа дууссан бүтээгдэхүүн эзэлсэн байна. Тодруулбал, томоохон хүнсний захуудад худалдаж байсан тоглоомтой чихэр, өндгөн шоколад, бохь, иштэй чихэр, кремтэй кеке зэрэг бүтээгдэхүүн хаяг шошгын зөрчилтэй байжээ. Шалгалтад 432 иргэн, аж ахуйн нэгж хамрагдсанаас 276 зөрчлийг газар дээр нь арилгаж, гурван аж ахуйн нэгжид 1.7 сая төгрөгийн торгууль ногдуулжээ. Дашрамд дурдахад, НМХГ-ын төв лабораторид энэ онд шинжилсэн хиа, хиаман бүтээгдэхүүний 6.6 хувь, архи согтууруулах ундааны 17 орчим хувь нь эрүүл ахуйн шаардлага хангаагүй бүтээгдэхүүн байжээ. Тиймээс иргэдийг хүнсний бүтээгдэхүүний хадгалах хугацаа болон аюулгүй байдлыг сайтар шалгаж авахыг тус газраас анхаарууллаа. [ЗГМ]

ХӨТӨЧ Ханиад томууны талаарх зөвлөгөөг утсаар өгч байна

Нийслэлийн Эрүүл мэндийн газраас гаргасан албан үүргийн дагуу томуу, томуу төст өвчний талаарх зөвлөгөө, мэдээллийг дүүргийн эрүүл мэндийн төвүүд долоо хоногийн бүх өдрүүдэд утсаар дамжуулан иргэдэд хүргэж байна. [ЗГМ]

- Багануур дүүргийн эрүүл мэндийн төв 70210290
- Налайх дүүргийн эрүүл мэндийн төв 70233464
- Багахангай дүүргийн эрүүл мэндийн төв 7049103, 0222103
- Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төв 70110278
- Хан-Уул дүүргийн эрүүл мэндийн төв 345903
- Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн төв 350793
- Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төв 70150063, 70150049
- Сонгинохайрхан дүүргийн эрүүл мэндийн төв 98254999
- Баянгол дүүргийн эрүүл мэндийн төв 362539

ТВ ХӨТӨЛБӨР

	MNB	Bloomberg	Боловсрол	Монгол ТВ
08.00	09.00 “Ганган хар” УСК	07.00 Ажил хэрэгч өглөө	08.00 “Монголчууд XX зууны эхэнд” нэвтрүүлэг	09.30 “Тог тог тог” (season-6) 16 дугаар анги
12.00	11.00 “Монголын мэдээ” мэдээллийн хөтөлбөр (шууд)	11.00 Made in Mongolia: “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК	11.20 “Оддын академи” шоу нэвтрүүлэг	11.40 “Пэппа торой” хүүхэддэйн кино (season-1) 5-8 дугаар хэсэг
14.00	15.45 Эргэж дөрвөн цаг	14.00 Суутнуудын намтар	14.00 “Флаш” ОАК хоёрдугаар бүлгийн, 18 дугаар анги	14.00 “Чассс...” COOK SHOW нэгдүгээр хэсэг
18.00	17.55 Эх орны төлөө	17.00 Bloomberg Surveillance	17.05 “Луунууд” хүүхэддэйн кино 1-2 дугаар анги	18.00 Орчин үеийн гэр бүл ОАК (season-8) дөрөвдүгээр хэсэг
20.00	21.10 “Ногоон сум” реалити шоу	20.00 Бизнес аялал	20.35 “Хүрээлэн” амьд ертөнцийн нэвтрүүлэг	21.00 “Чамайг унтаж байхад...” COAK наймдугаар анги
22.00	22.35 “Битлз: Хүндхэн өдрийн дараах үдэш” УСК	22.00 Өсөлтийн замд	00.05 “Кино миний амьдрал”	22.30 “Хавай 5-0” ОАК (season-7) 25 дугаар анги

ОНЦЛОХ ҮЗЭВЭР “Шинэ жилийн ТОГЛОЛТ”



Монгол Улсын Морин хуурын чуулгын жил бүр уламжлал болон тоглогддог шинэ жилийн тоглолт энэ сарын 24-ний 18.00 цагт Тусгаар тогтнолын ордонд ганцхан удаа болох гэж байна. Тоглолтод дэлхийн вальсын хаан И.Штраус, Оросын суут хөгжмийн зохиолч П.И.Чайковский, Чехийн алдарт хөгжмийн зохиолч А.Дворжак зэрэг сонгодог үеийн төлөөлүүдийн гайхамшигт аялгуунууд эгшиглэхээс гадна орчин цагийн хөгжмийн шилмэл бүтээлүүд тоглогдох болно. Тоглолтод урилгаар МУГЖ дуучин Б.Сарантуяа, УДБЭТ-ын гоцлол дуучин, СТА Б.Энхнаран, СТА Б.Батжаргал, Улсын филармонийн гоцлол дуучин Б.Монголхүү, Авыяаслаг монголчууд шуоны 2016 оны ялагч дуучин О.Энх-Эрдэнэ нар оролцоно. [ЗГМ]

ҮЗЭВЭР



Улаанбаатар хотын хүүхдийн театраас зохион байгуулж буй “FROZEN Зул сар” хүүхдийн тоглолт энэ сарын 23-нд 13.00, 15.00 цагт болно. Тасалбар 15 мянган төгрөг бөгөөд бэлэгтэй дагана.



Монголын хамгийн анхны бага театрын үзэгч хүүхдүүдийн оролцоот жүжиг энэ сарын 16-31 хүртэл тоглогдоно. “Бүтээлч Бамбуу” байгууллагын доорх Бамбуу театрын хамгийн анхны уран бүтээл болох “Гурван бяцхан тоорой” хүүхдийн жүжгийг Английн ардын үлгэрээс сэдэвлэн Сергей Михайловын жүжгэн хэлбэрт оруулсан шинэлэг хувилбараар хүргэх аж. Тасалбарын үнэ 10-15 мянган төгрөг.



Германы алдарт “Boney M” хамтлаг энэ сарын 30-нд Crocus Event Hall-ын тайзнаа тоглоно. Тасалбарын үнэ 150 мянган төгрөг бөгөөд баярын ширээний багц үүнд багтжээ.



“Очир таягны эрэлд” жүжигт өвлийн төхөөрхөө барьж явдаг очир таягны ухай гарна. Очир таяг нь он солигдох торгон мөчийг авчирдаг гайхамшигт ид шидтэй билээ. Гэвч очир таягнаас илүү ид шид энэ хорвоо дэлхий дээр байдаг юм. Тэр бол хүүхэд бүр нэг нэгнийгээ уучлах, хайрлах сэтгэл билээ. Энэхүү жүжиг энэ сарын 23, 24-нд 14.00, 16.00 цагт тоглогдоно.



Хүүхэд гэлтгүй хүн бүрийн хүсэн хүлээдэг П.И.Чайковскийн “Щелкунчик” балет энэ сарын 21-24-нд 17.00, 19.00 цагуудад тус тус тоглогдоно. Мариус Петипа, Э.Т.А.Хоффманы “Цөмөөхэй ба Хулганы хаан” зохиолоос сэдэвлэсэн цомнолыг барууны орнуудад 1940-өөд оноос тоглож эхэлжээ. Зул сарын баяраар хамгийн олон удаа тоглогддог энэхүү бүтээлээр Америкийн томоохон балетын компаниуд жилийн орлогынхоо 40 хувийг бүрдүүлдэг аж.

ЗУРХАЙ



Билгийн тооллын 30

Өвлийн тэргүүн цагагчин гахай сарын нэг цагаан мэнгтэй шаргагчин туулай өдөр
Үзэсүүлбэл: Эрлэг лугаа учирна
Наран ургах, шингэх: 08.41-17.02
Барилдлага: Рашааний
Шүтэн барилдлага: Сэрэхүй
Суудал: Отгоргүй

Ардын тооллын арванхоёрдугаар сарын 18, Сумъяа гараг. Билгийн тооллын битүүн, Гар одтой, шаргагчин туулай өдөр.

Өдрийн наран 08.41 цагт мандан, 17.02 цагт жаргана. Тухайн өдөр хонь, гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр эм эмнэлгийн элдэв үйл, хагалгаа хийлгэх, биеийн тамирыг сэргээх, угаал үйлдэх, мал аж ахуйн үйл, удирдлагын суудалд суух, отгоргийн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн. Газар гахалах, ус, булгийн эх малтах, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогдод зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.



Москва-УБ	21:35	07:30
УБ-Эрхүү	21:10	02:40
Эрхүү-УБ	15:35	06:20
УБ-Замын-Үүд	20:00	07:50
Замын-Үүд-УБ	21:35	09:55




УБ-Сөүл	07.45	12.05
Сөүл-УБ	13.20	16.05
УБ-Бээжин	08.15	10.30
Бээжин-УБ	11.30	14.00
УБ-Токио	08.55	14.30
Токио-УБ	15.30	20.25

ХУЧИНГҮЙД ТООЦОВ

“Бээжин Юни Констракшн Групп” ХХК-ийн 5754208 регистрийн, 9019075011 улсын бүртгэлийн дугаартай улсын бүртгэлийн гэрчилгээ болон тамгыг гээгдүүлсэн тул хучингуй болсонд тооцов.

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ




3. Спортын тэмцээний шүүгчийн хэрэглэх зүйл
5. Нэгэн ижил цэгээс эхлэлтэй, хоёр цацрагаар бүтсэн дүрс
6. Хөлбөмбөгийн эх орон
8. Дөрвөн жил амьдарч, түрсээ шахаад үхдэг загас
10. Сансарт ниссэн анхны амьд амьтан болох нохой
11. Дээд ургамлын нэгэн
- адил байгальд асар их ач холбогдолтой усан дахь эгэл биет
12. Олимпын наадмыг зохион явуулсан Ази тивийн анхны хот

Өмнөх дугаарын хариу / 12.15



ЦАГ АГААР

УЛААНБААТАР	XII.18	XII.19	XII.20	XII.21	XII.22
	-12° 6 м/с -21° 5 м/с	-9° 7 м/с -17° 5 м/с	-9° 7 м/с -18° 5 м/с	-10° 5 м/с -18° 6 м/с	-8° 5 м/с -17° 6 м/с
	Үүшинэ	Ялимгүй цастай	Үүшинэ	Үүл багасна	Үүшинэ



ЗГМ: КОМИКС

Mr. Баагийгийн БОДРОЛ.....

Хэрэгтэй хэрэггүй олон даатгал байх юм... Бил дуртай дургүй хуулийн дагуу жолоочийн хариуцлагын даатгал төлсөн.

Баагий даатгалын ойлголт муутай түл эрсдэлийн асуудалд хойрго хандагч нэгэн

Миний ч явах ингэд боллоо, тээврийн хэрэгслээ зэрэг даатгуулахгүй. Яана даа, чи...

Жолоочийн хариуцлагын даатгал нь таны буруутай үйлдлээс учруулсан хохирлыг таны өмнөөс хохирогчид нөхөн төлдөг даатгал юм. 2015 онд 30,909 даатгуулагчдад 14.5 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон.

Ээ... энэ хэцүү цагт даатгал л амьнд орно шүү... тээврийн хэрэгслээ бас даатгуулчихсан, хашир нь л дээр...

Жолоочийн хариуцлагын даатгал таны бусдад учруулсан хохирлыг төлдөг бол тээврийн хэрэгслийн даатгал таныг хамгаална.

Гай газар доороо гэж... эрсдэл хэзээ ч гарна.

Бүрэн даатгалтай тулдаа л хоеулаа хохиролгүй өнгөрлөө.

Баагий жолоочийн хариуцлагын даатгал, тээврийн хэрэгслийн даатгал даатгуулснаар өөрийгөө болон бусдын эд өөрийн эрсдлээ хамгаалсан юм.

© The Financial Times Limited (2015). All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

Биткоины фьючерс гаргах өрсөлдөөн

Фьючерсын үйлдвэрлэл эрхлэгчдэд биткоин нь учир үл олодог шинэ зүйл. > 10

Донтсон өсвөр насныхнаас гар утсыг нь холхон байлгахар болов

Шинэ төслөөр 16-гаас доош насныхан Facebook-д аккаунт нээхдээ эцэг эхээсээ зөвшөөрөл авна. > 10

ТВ, дэмжлэг хоёрын ачаар хятад оддын орлого өсөж байна

Хятадын шилдэг 10 одын орлого энэ онд 2015 оныхоос 166 хувиар өссөн үзүүлэлттэй гарлаа. > 10

Хятадыг эдийн засгийн түрэмгийлэлд буруутгана

Нөгөө талаар, Бээжин Пхеньянд чухал нөлөөтэй гэж үзэж байсан тул бодлогоо чангатгахаас түдгэлзэж байв. Гэвч Трамп сарын өмнө АПЕК-ын уулзалтаас эргэж ирээд Азийн орнуудтай хийдэг худалдааны ужиг алдагдлыг цаашид гэвчихгүй гэж мэдэгдсэн юм. Дээрх стратегийг боловсруулах ажлыг удирдаж буй АНУ-ын Үндэсний аюулгүй байдлын зөвлөх МкМастер Хятадыг “Оростой адил олон улсын дэг журмыг эвдэхийг оролддог ревизионист улс” хэмээн шүүмжилжээ.

Энэ удаад худалдаа, эдийн засгийн асуудлыг стратегид шинээр оруулж байна. Цагаан ордны Үндэсний аюулгүй байдлын зөвлөл энэ талаар тайлбар өгөхөөс татгалзав. Бушийн захиргаанд ажиллаж байсан Майкл Аллен “Энэхүү стратеги бол Хятадын эсрэг авах эдийн засгийн арга хэмжээний эхний

(буун дуу) юм” гэв. Түүнчлэн энэ нь АНУ Хятадыг Дэлхийн худалдааны байгууллагад элсэхийг дэмжсэнээс хойш авах хамгийн хатуу арга хэмжээ болно гэж шинжээчид таамаглаж байна.

Ардчилсан нам болон үйлдвэрчний эвлэлүүд Трамп сонгуулийн сурталчилгаандаа Хятадын талаар ярьж байсан зүйлээ хэрэгжүүлсэнгүй хэмээн шүүмжилдэг. Үүний зэрэгцээ Хятадын ган үйлдвэрлэл ба оюуны өмчийн асуудлаарх мөрдөн байцаалт удахгүй дүнгээ гаргана. Эдгээр үйл явц нийлээд Хятадын эсрэг хориг болон тариф нэмэх арга хэмжээнд хүргэж магадгүй юм. АНУ-ын худалдааны төлөөлөгч, эдийн засгийн үндэсрэх үзлээрээ нэрд гарсан Роберт Лайтхайзер Хятадтай худалдааны талаар хатуу бодлого хэрэгжүүлэхийг хэдийнээс шаардаж буй. Гэвч зарим шинжээч хэт хатуу арга

хэмжээ худалдааны дайнд хөтөлж, АНУ-ын ба дэлхийн эдийн засагт хохирол учруулж болзошгүй хэмээн болгоомжилж байна.

Тухайлбал, Хятадыг эдийн засгийн түрэмгийлэлд буруутгаж, стратегийн өрсөлдөгч хэмээн нэрлэсний дараа Бээжин хариу барьж, Америкийн компаниуд

ачааг нь үүрч магадгүй юм. Ерөнхийлөгч Обамагийн зөвлөх асан Эван Медейрос “Хятадын худалдааны бодлого ба практик нь ноцтой бодит түгшүүр мөн боловч яаж шийдэх вэ гэдэг нь асуудал. Нэг талын худалдааны албадлага үр дүнд хүрэхгүй. Хятадын эдийн засгийн орчныг өөрчлөх системтэй арга хэрэгсэл

шаардлагатай” хэмээв.

АНУ-ын засаг захиргаа Хойд Солонгостой худалдаа, санхүүгийн харилцаагаа үргэлжлүүлж буй Хятадын томоохон банкуудад хориг тавих тухай ярьж байгаа боловч ганц жижиг банкны эсрэг арга хэмжээ авсан. ТТГ-ын шинжээч асан Деннис Уайлдер “Хятадын гол банкуудад хориг

тавих нь ихээхэн эрсдэлтэй. Пхеньяны цөмийн асуудлаар Вашингтонтой хамтрахыг хүсэхгүй байгаа Хятадын дээд удирдлагын зарим хүн АНУ уг асуудлыг шийдэхэд үнэн санаанаасаа хандахгүй байна гэж хэлэх болно” гэж анхаарууллаа.

BWM©

FT


Даатгалынхан ухаалаг орон гэрт найдаж байна

Оливер Ральф

Патрик Милне цахим хэрэгсэлд дуртай. Лондон дахь түүний унтлагын дөрвөн өрөөтэй байранд хаалга, хөдөлгөөн ба утаа мэдэрэгч, хий хянагч, дотоод камер зэрэг юмс бий. Мэдээж тэдгээр нь түүний гар утастай холбоотой. Ноён Милне энэ бүхнийг авахад ганц ч зоос зараагүй гэнэ. Харин Neos хэмээх даатгалын компани уг хэрэгслүүдийг даатгуулах гэрээний хамт өгчээ. Үнэгүй олгосон шалтгаан нь маш энгийн. Даатгагчид нөхөн олговрыг багасгах зорилгоор иргэдийг ноён Милнегийн жишээг дагахыг уриалж байгаа юм. Тэрбээр “Үерийн мэдрэгч тавьснаас хойш долоо хоноод л хэрэг нь гарсан. Ус буцалгагчаас шал руу дусаал гоожиж байсныг хэдхэн мөчийн дараа л мэдэвч, бид дор нь хувин тавьсан. Хэдэн зуун паундын хохирол гарахаас сэргийлж, шалаа арчих ажил хийсэн” хэмээв.

Интернетэд холбогддог гэрийн ухаалаг хэрэгслийн зах зээл түргэн өргөжиж, Google, Amazon зэрэг технологийн томчууд анхаарал хандуулж эхэллээ. IHS Markit фирмийн тооцоолсноор гэрийн ухаалаг хэрэгсэл энэ онд 100 сая ширхэг борлогдсон бол 2021 онд 600 саяд хүрэх төлөвтэй байна. Гэвч эдгээрийг гэрт тавьснаар үүсэх нэг гол эрсдэл нь хакерууд айлд юу байгаа, хэдийд эзгүй байх, хаалгаар нь хэрхэн нэвтрэхийг мэдэж авах боломжтой. Amazon саяхан гэрийн эзэд байхгүй үед шуудан хүргэгч орж болдог цоож бүтээжээ.

Гэвч Neos ухаалаг цоож санал болгодоггүй. Компанийг үндэслэгч Мэтт Полл “Судалгаанаас үзэхэд хэрэглэгчид ийм цоожинд дуртай биш. Тэд хакеруудлахаас болгоомжилдог. Иймээс ухаалаг цоож амьдралд нэвтрэхгүй



байгаа юм” гэж яриу. Apple-ийн ухаалаг цоожийг хакерууд нээх боломжтой нь илэрсэн тул саяхан HomeKit системээ засахад хүрчээ. Цөөхөн даатгалын компани л ухаалаг цоожтой байр хэрхэн даатгах үнийн бодлого боловсруулсан байна. Ageas даатгалын ажилтан асан Лей Калтон “Ямар ч хэрэгслийг интернетэд холбосон бол хакеруудлах эрсдэл үүсдэг. Цөөн даатгагч уг хэрэгслийн өгөгдлийн талаар бодит мэдлэгтэй байдаг. Тэд танай гэр таван давхар цоожтой гэдэгт үндэслэхээс бус ухаалаг цоожтой гэдгээр даатгалын үнээ тооцохгүй” гэсэн байна.

Гэхдээ даатгалын компаниуд хэрэглэгчидтэй харилцах арга замаа өөрчлөхийн тулд ухаалаг цахим мэргэжилтэн Шон Ринстед “Технологи даатгагч ба байр эзэмшигчдийн харилцааг үндэс нь өөрчилж байна. Засах, солихын оронд таамаглах, сэргийлэх бодлого руу шилжиж байгаа. Одоо эрсдэлийн мөнгө төлөхөөс илүүтэй үйлчилгээ нь өөрөө бүтээгдэхүүн болсон” гэжээ. Chubb ганцаараа энэ

чиглэлд ажиллаж байгаа бус. Британийн RSA, Aviva компани ухаалаг орон гэрийн даатгал руу шилжих алхам хийж эхэлжээ.

Уг зах зээл түүнчлэн гарааны бизнесүүдийн анхаарлыг татжээ. Neos-оос гадна Buzzmove компани айл нүүлгэхийн сацуу сүлжээний хэрэгсэлд суурилан орон байр даатгах үйлчилгээ эхлэхээр шийдсэн аж. Байрны даатгалын PolicyCastle старт-апп орон байрны аюулгүй байдлыг хангах Sosoop систем суурилуулбал даатгалын үнээ 15 хувиар хөнгөлөхийг санал болгов. Гэхдээ салбарын зарим хуучуул нэг их яарахгүй байгаа бололтой. Ноён Калтон ярихдаа “Даатгагчдын алдаг нэг зүйл бол хэрэглэгчийн оролцоо юм. Зарим нь өдөр бүр, долоо хоногтоо хэрэглэгчидтэйгээ харилцдаг гэж нотолдог. Гэтэл хэрэглэгч яагаад ийм харилцааг хүсэх ёстой гэж” хэмээв.

Сүлжээнд холбогдсон орон байр янз бүрийн эрсдэлд өртөх магадлалтай бөгөөд хувийн эрх ашгийг хамгаалах бүлгүүд “Айл өрхүүд технологийн том компаниудын ажиглалтад хамрагдах үүд хаалгаа санамсаргүй нээж байна” гэж үздэг. Accenture зөвлөх фирмийн захирал Мэтт Леман “Итгэл

ба хувийн нууц хоёр үнэхээр эрсдэлд ордог... Хэрэглэгчид тэдний мэдээллийг ашиглаж болзошгүй гэдгийг ойлгох ёстой. Даатгагч хэрэглэгчдэд ил тод байх нь маш чухал” гэв. Гэхдээ ухаалаг орон байрны даатгалын тогтолцоо нэвтрэх үйл явц удаашрах боломжтой.

Жишээ нь, “хар хайрцаг” буюу машинд жолоочийн үйл ажиллагааг үнэлэх төхөөрөмж тавьж, аюулгүй жолооддог хүнд хөнгөлөлт олгох систем дээр эхэлсэн боловч өдий хүртэл бүрэн хэрэгжсэнгүй. Нэг шалтгаан нь төхөөрөмжийн өртөг юм. Британийн автомашины даатгалын үнэ 500 паундаас бага бөгөөд саяхныг хүртэл 100 паундаас дээш үнэтэй байсан хар хайрцгийг худалдаж авах санхүүгийн шалтгаан байхгүй юм. Ийм асуудал ухаалаг орон байрны хэрэгсэлд тохиолдож болзошгүй. Ноён Калтон “Одоохондоо санхүүгийн учир шалтгаан бүрдээгүй байна” гэжээ.

Neos-ын санал болгож буй хэрэгслүүд 700 паундын үнэтэй байгаа Британийн байр ба эд хогшлын даатгалын үнэ 300 паунд байгаагаас нэлээд дээгүүр зардал. Ноён Полл даатгалын компани бөөнөөр худалдан авдаг ба нөхөн олговрыг багасгах, хэрэглэгч урьдчилгаа төлнө гэсэн итгэлд суурилан цахим цаашид хамтарна гэж байв. Ноён Милне “Хэн нэг нь гайхалтай гэрээ санал болгохгүй бол би хуучнаа солихгүй. Би технологийн тоглоомд дуртай боловч энд хэцүү юм байхгүй. Би юм эвдэхдээ гарамгай хүн. Гэхдээ үүнийг эвдлэхэд маш хэцүү” хэмээн өгүүллээ.

Д.Камерон "Нэг зам, нэг бүс" сангийн удирдлагад оржээ

Эмили Фен, Хенри Манс

Британийн Ерөнхий сайд асан Дэвид Камерон Хятадын “Нэг зам, нэг бүс” төслийн тэрбум ам.долларын хөрөнгөтэй санд удирдах үүрэг гүйцэтгэхээр боллоо. Улсын гүйцэтгэлтэй санг Британи, Хятадын хувийн байгууллагууд удирдах бөгөөд ноён Камерон тэргүүнээр батлагдах юм байна. Британийн Сангийн сайд Филип Хаммонд Бээжинд хоёр өдрийн айлчлал хийх явцдаа хөрөнгө оруулалтын шинэ хэлцлийг эцэслэв. Тэрбээр Лондон 2019 Европын холбооноос гарахын өмнө дэлхий даяар худалдааны харилцаагаа өргөжүүлэх зорилго өвөртлөжээ. Ноён Камерон есдүгээр сард Хятадад ирэхдээ хамтарсан сангийн тухай хэлэлцээ хийсэн аж.

Тэрбээр өнгөрсөн долдугаар сард Брекситийн асуудлаар санал асуулгад ялагдаж, огцорсныхоо дараа нам гүмхэн байсан. Энэ үеэр альянсийн өвчин болон ДОХ-ын эсрэг кампанит ажилд оролцож байв. Харин саяын айлчлалынхаа үеэр ноён Хаммонд Камероныг даргын суудалд очиж магадгүй гэсэн боловч уг сан бол хувийн санаачилга гэдгийг онцоллоо. Эхс Ерөнхий сайдын найз бизнесмен Питер Паддингтон уг санг үүсгэн байгуулахад оролцсон аж. Сан болон хөрөнгө оруулалтын бусад санаачилга Британи, Хятадын харилцааны алтан үеийн шинэ алхам болно гэж шинжээчид бичжээ.

Хятадын Ерөнхий сайдыг орлогч Ма Кай “Хятад Британийн харилцаа бол дэлхийд

хамгийн чухал хоёр талын харилцааны нэг” хэмээн үнэлсэнээр 2019 оны гуравдугаар сард Британи Европын холбооноос гарахад харилцаа суларч магадгүй гэсэн болгоомжлолыг арилгав. Ноён Хаммонд “Саяын байгуулсан гэрээүүдийн үр дүнд бизнес, санхүү, худалдаа урьдын адил үргэлжилнэ” гэж үзэж буйгаа илэрхийллээ. Бямба гарагт гарын үсэг зурсан нэг гэрээний дагуу Лондоны гадаад валютын зах зээл дээр Хятадын юанийн худалдах шууд суваг нээх аж. Гэхдээ Шанхай, Лондоны хөрөнгийн биржийн хооронд шууд суваг нээх огноог заагаагүй байна. Хоёр тал 2015 оноос хойш энэ талаар ярилцсан боловч найман цагийн зөрүүг хэрхэн шийдэх асуудалд хүндрэл гараад байсан юм. Хоёр талын олонх гэрээ “Нэг зам, нэг бүс” төсөлд чиглэгджээ.

Британийн Export Finance агентлаг Азийн төслүүдэд зориулж 25 тэрбум паундын хөрөнгө босгоход туслахаа мэдэгдлээ. Тус улс Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын хөрөнгө оруулахаа зарлажээ. БНХАУ 2015 онд уг банкныг 100 тэрбум ам.долларын хөрөнгөтэйгөөр Дэлхийн банктай өрсөлдөхүйц түвшинд байгуулсан билээ. Ноён Хаммонд “Хятад улс үйлдвэрлэл, барилгын чадамж болон асах их капиталын нөөцтэй. Британи санхүү, хуулийн үлэмж туршлагатай тул нягт харилцах маш их боломжтой” хэмээн мэдэгдсэн байна.

FT

Грегори Майер, Филип Стаффорд

Биткоины үнэ лхагва гарагийн өглөө гэнэт 10 хувиар унах үед хөрөнгө оруулагчдын зарим нь шүхрээр үерэхийг илүү аюулгүйд тооцож байсан болов уу. Гэхдээ хөдөлгөөнгүй царцмал зах зээл жоохон ч атугай амь ороосой хэмээн горьдож байсан арилжааны компаниудад биткоины үнийн өсөлт тун ч утга учиртай. Зохицуулалттай фьючерсын биржид арилжаа хийх нь сэтгэл догдлуулсан ажил болж хувирлаа. Сбое-гийн өрсөлдөгч CME Group биткоины фьючерсын арилжаагаа даваа гарагт эхэлнэ.

Криптовалютын үе эхэлж буйг тунхаглагч биткоины фьючерс нь санхүүгийн тогтолцоонд заналхийлэгч шинэ эрсдэл үү, эсвэл бас нэг тэнгэргэлийн оргил уу гэсэн асуулт арилжаач, зохицуулагч нарт тулгараад байна. Асуултын хариуг арилжааны явц харуулж өгнө.

Анх 2008 онд төлбөрийн хэргэсэл болгон үүсгэсэн биткоин нь нэг төрлийн аз туршилт. Өдөрт хоёр оронтой тоогоор үндэ орж буй биткоины ханш энэ онд 1600 хувиар өссөн нь урьд хожид тохиолдож байгаагүй үзэгдэл юм.

АНУ-ын фьючерсын бирж XIX зуунаас эхтэй. Олон арван жилийн туршлага, хааяа нэг тохиолддог дуулиант хэргийн үр дүнд энэхүү үйлдвэрлэл үйлчлүүлэгч нараа үнийн гэнэтийн өөрчлөлт, брокерын алдаанаас хамгаалж өгдөг бат бэх тогтолцоотой болжээ. Гэхдээ фьючерсын үйлдвэрлэл эрхлэгчдэд гэнэтийн нь учир үл олдох шинэ зүйл.

АНУ-ын зохицуулах байгууллага болох Таварын фьючерсын арилжааны комисс (CFTC-Commodity Futures Trading



CFTC-ийн Кристофер Жианкарло, CME Group-ын Терри Даффи, Interactive Brokers-ын Томас Питерфлай, Сбое-ын Крис Конканнон

BBM©

Биткоины фьючерс гаргах өрсөлдөөн

Commission) биткоины гэрээ байгуулах зөвшөөрөл олгосон нь тохиолдож болзошгүй ирээдүйн шинэ аюулаас болгоомжлох айдсыг зарим арилжаачдад тэрүүлэв.

Interactive Brokers-ын тэргүүн Томас Питерфлай сэтгэл зовж буй хүмүүсийн нэг. “Би 1968 оноос хойш фьючерсын үйлдвэрлэлд оролцож байгаа хүн. Фьючерсын брокерууд дампуурснаас үйлчлүүлэгч нар нь хамаг мөнгөө алдаж байхыг зөндөө үзлээ. Энэ зах зээл яаж ажиллагдгийг би

ойлгоно” хэмээн тэрбээр өгүүлсэн юм.

Interactive фьючерсын брокерын компани нь үйлчлүүлэгчдийнхээ өмнөөс арилжаа явуулж, бооцооноос ахиуц ашиг олох замаар ажилладаг. Тус компани биржийн клирингийн танхимын гишүүн учраас бусад брокер төлбөрийн чадваргүй болох нь ч сөрөг нөлөөтэй.

Биржүүд биткоины фьючерс гаргах гэж буйг мэдмэгцээ ноён Питерфлай болгоомжлуулах

зорилгоор CME-гийн гүйцэтгэх захирал Терри Даффи, CFTC-гийн тэргүүн Кристофер Жианкарло нартай ярилцжээ. “Яах аргагүй болж буй ажиллагаа” хэмээн ноён Даффи тайлбарласан бол ноён Жианкарло “Гар хүлээтэй сууж буй”-гаа өгүүлж байсныг тэрбээр дурссан юм.

Ноён Даффи дараахан нь ноён Жианкарлод хандаж захиа бичсэн нь Wall Street Journal-д нийтлэгдлээ. Тэрбээр захидалдаа биткоины фьючерсын клирингийн

танхим тусад нь байгуулахыг захирал Терри Даффи, CFTC-гийн тэргүүн Кристофер Жианкарло нартай ярилцжээ. “Яах аргагүй болж буй ажиллагаа” хэмээн ноён Даффи тайлбарласан бол ноён Жианкарло “Гар хүлээтэй сууж буй”-гаа өгүүлж байсныг тэрбээр дурссан юм.

Танхим тусад нь байгуулахыг захирал Терри Даффи, CFTC-гийн тэргүүн Кристофер Жианкарло нартай ярилцжээ. “Яах аргагүй болж буй ажиллагаа” хэмээн ноён Даффи тайлбарласан бол ноён Жианкарло “Гар хүлээтэй сууж буй”-гаа өгүүлж байсныг тэрбээр дурссан юм.

черсыг биржүүдтэй ид тохиролцож байсныг уг яриа хэлэлцээрт оролцсон эх сурвалж батлав. Зохицуулах байгууллага Сбое-той долдугаар сард, CME-тэй аравдугаар сарын дундуур тохиролцсон CFTC-ийн болзошгүй зах зээлийн салбар хариуцсан захирал Амир Зайди тус байгууллагын подкастад тайлбарласан байна.

Шинэ гэрээний зөвшөөрөл гаргуулах нь түвэг ихтэй нүсэр ажиллагаа. Зохицуулах байгууллагууд асуудлыг сулдаж хугацаа их шаарддаг. CME анх гэрээний үнийн 27 хувиар тооцож ахиуц ашгийн баталгаа гаргуулахаар чармайж байсныг CFTC-гийн клиринг, эрсдэлийн хэлтсийн захирал Брайан Басси өгүүллээ. Дараа нь “бидэнтэй зөвлөлдөөд хэмжээгээ 35 болгон өсгөсөн” хэмээн тэрбээр нэмж дурдсан юм.

Энэ долоо хоногт CME ахиуц ашгийн хэмжээг 43 хувь хүртэл өсгөв. Улмаар Sboe, CME, Cantor Exchange гурав “өөрсдөө сертификатжуулж” шинэ дериватив бүтээгдэхүүн - биткоины опцион үүсгэхээр болсныг CFTC арванхоёрдугаар сарын 1-нд зарлажээ. Interactive-ыг оролцуулаад 64 гишүүнтэй Фьючерсын үйлдвэрлэлийн холбоонд энэ нь таагүй арга хэмжээ боллоо. Учир нь тус байгууллагын гишүүдийн ихэнх нь шинэ гэрээг дэмжиж байгаа юм.

CME, Sboe аль аль нь зах зээлд эртхэн гарч авах учир шалтгаантай. Фьючерс гаргах нь “ялагч бүгдийг хамаа” бизнес болдог. Учир нь шинээр гарах гэрээг бирж хооронд дамжуулдаггүй. Харин тухайн биржийн арилжаа их байх тохиолдолд арилжаач нарт өөр биржид очих шалтгаан төдийлөн байхгүй.



Донтсон өсвөр насныхнаас гар утсыг нь холхон байлгахгаар болов



BBM©

Харриет Агньо

Технологид донтсон өсвөр үеийнхэн нийгмийн эрүүл мэндийн ноцтой бэрхшээл болж хувирсныг сануулагч Франц улс гар утас, олон нийтийн сүлжээг хүүхдүүдээ холдуулах арга хайж эхэллээ. Өгөгдлийн халдашгүй байдлын цогц хуулийн бүрдэлд

багтаж буй шинэ төслөөр 16-гаас доош насны франц хүүхдүүд Facebook, Snapchat, Instagram зэрэг олон нийтийн сүлжээнд хаг нээхийн тулд эцэг, эхээсээ зөвшөөрөл авах ёстой.

Ирэх жилээс эхлэн Францын бага, дунд, ахлах сургуульд гар утсыг хориглохоор болсныг

боловсролын сайд Жан-Мишель Бланке мэдэгдсэнтэй давхцан шинэ төсөл гарч байна. Уг хориг нь Эммануэль Макрон сонгуулийн кампанийнаа үеэр амласан амлалтаа хэрэгжүүлж буйн баталгаа юм.

Францын сургуулиудын анги танхимд гар утас ашиглах урьд

нь ч хориотой байв. Харин энэ оны есдүгээр сараас сурагчдыг завсарлага, хоолны цагаар, хичээл хооронд гар утас ашиглахыг нэмж хоригложээ.

Хоёр хориг аль аль нь Францын олон нийтийн дэмжлэг хүлээсэн байна. “Сургуулиудад гар утас ашиглахыг хориглосон нь эмзэг асуудал” хэмээн эрсдэлтэй хөрөнгө оруулалтын Accel Partners компанийн Пиа д’Ирибарн тайлбарлав. “Хүүхдүүд гар утсаараа тоглож цаг өнгөрөөх нь юм сурахгүй, үе тэнгийнхэнтэйгээ харилцахгүй гэсэнтэй адил” хэмээн тэрбээр анхааруулсан юм.

Хүүхдүүд интернет, олон нийтийн сүлжээ ашиглахад хяналт тогтоох нь хүнд ажил гэдгийг экспертүүд анхааруулдаг. “Интернет, олон нийтийн сүлжээ нь хүүхдүүдэд кибер дон тусах, дээрэлхүү, зожиг болох, нойрны хэмнэл алдагдах, онлайн порнограф, хүчирхийлэлд автуулах

аюултай”-г социологийн ухааны профессор Паскаль Ларделе тайлбарлав. “Гэхдээ хүүхдүүд улам бага насандаа интернет хэрэглэх болж байгаа энэ нөхцөлд эцэг эх, Засгийн газар хэрэглээг нь хянана гэдэг бодит байдалд үл нийцэх, бүтэштгүй санаа” хэмээн тэрбээр анхааруулав.

Facebook зэрэг олон нийтийн сүлжээнд 13-аас доош насныхан бүртгүүлэхийг тус улсад мөн л хоригложээ. Гэтэл судалгаанаас үзвэл янз бүрийн сэжигтэй болзооны сайтуудад бүртгүүлэх эрсдэл 14-15 насныхны дунд хамгийн өндөр гарсныг Францын Хууль зүйн сайд онцлон анхааруулав.

Европын холбооны зохицуулалтаар хүн 16 нас хүрсэн бол олон нийтийн сүлжээнд бүртгүүлж болно. Гэхдээ тус холбооны гишүүн орнууд насны хязгаарлалтыг үүнээс ч доош тогтоох эрхтэй. Жишээ нь Британид насны хязгаарлалтыг 13-аар тогтоосон. Хэнтэй

харьцахыг эцэг, эх нь шийддэг мессеж аппликэйшныг Facebook зургаан настнуудад зориулан саяхан бүтээжээ. Бүр нялх балчир үеийнхний анхааралгатай зорилготой уг арга хэмжээний дараахан Францад дээр өгүүлсэн хуулийн төсөл гарчээ.

Бэлгийн утга агуулга бүхий тайлбартайгаар хүүхдүүдийн бичлэг байршуулж байна гэсэн нийтийн шүүмжлэлд YouTube сайт үеийнхний анхааралгатай зорилготой уг арга хэмжээний дараахан Францад дээр өгүүлсэн хуулийн төсөл гарчээ.

Facebook 13-17 насныханд зориулсан хамгаалалт, аюулгүй байдлын тусгай аргачлал мөрдөж ажилладаг. Тус компани кибер хүчирхийллийн асуудлаар Францын боловсролын хэд хэдэн хөтөлбөр санаачилгад оролцож байв. Гэхдээ 16-гаас доош насныханд хязгаар тогтоох нь урьдчилан таамаглах аргагүй үр дагавартайн зэрэгцээ залуу үеийнхний сурч мэдэх эрмэлзлийг мохоох аюултай хэмээн тус компани үздэг тухай мэдээлэлд ойр эх сурвалж тайлбарласан юм.

Францын боловсролын яамны боловсруулж буй сургуулиудад гар утсыг бүрмөсөн хориглох арга хэмжээний нарийвчилсан заалт ирэх онд тодорхой болно. Заалтад олон зуу, магадгүй олон мянган утсыг найдвартай хадгалах, багш нар сурагчдад гар утас байгаа эсхийг нэгжих гээд олон асуудал багтжээ.

Хүүхдүүд дэлгэц ширтэн өнгөрөөдөг хугацаа бүр “нийгмийн эрүүл мэнд”-ийн асуудал үүсгэж байгааг ноён Бланке тайлбарлав. “Одоогийн хүүхдүүд завсарлагаар тоглохоо больцоосон. Бүгд утасныхаа дэлгэц ширтэцгээж байгаа нь бөөн бэрхшээл учруулдаг” хэмээн тэрбээр англи хэлээр гардаг Local сонинд нийтлүүлсэн материалдаа бичжээ.

Асуудлыг дан ганц зохицуулалтаар бус, боловсрол мэдлэгийг нь дээшлүүлэх замаар шийдвэрлэх ёстойг энэ долоо хоногт France Digital зохицуулах агентлагийн захирлаар сонгогдсон Рэйчел Делакур өгүүллээ. “Утсаа хэт ихээр ашиглаж буйгаа хүүхдүүд өөрсдөө ухамсарлан дүн шинжилгээ хийж, биеэ татах чадвар суулгах нь чухал” хэмээн хатагтай Делакур анхааруулав.



ТВ, дэмжлэг хоёрын ачаар хятад оддын орлого өсөж байна

Том Хэнкок

Коммунист намаас дэмжихийн зэрэгцээ орлогыг нь хянахыг чармайдга хятад алдартнуудын элит хэсгийнхний орлого өсөж байна.

Хятадад 10-хан жилийн өмнө тасалбар борлуулалтын орлого нэг тэрбум ам.доллар ч хүрдэггүй байсан бол өнгөрсөн онд хэдийн зургаан тэрбум ам.доллар давжээ. Үүнтэй зэрэгцэн телевизийн цуврал кино хөгжин цэцэглэсний ачаар А зэрэглэлийн жүжигчдийн цалин өссөөр.

Тус улсын хамгийн өндөр орлоготой 10 од энэ онд 2.2 тэрбум юань буюу 330 сая ам.доллар олсон нь 2015 оны үзүүлэлтээс 166 хувиар өссөн үзүүлэлт болохыг Forbes тооцоолжээ. Жагсаалтыг 330 сая юанийн орлоготой кино од Жэки Чан манлайлж байна.

Онлайн драм бүтээх зардлын 70 хувь нь жүжигчдийн цалин болдгийг Бээжинд байрладаг нэрээ нууцлахыг хүссэн кино продюссер тайлбарлав. “Хятад драм одуудад түшиглэдэг. Сансрын гэмээр хэмжээстэй их мөнгө төлөөд байхад л ур чадварыг нь дутуу үнэллээ гэж шүүмжлэх

хүмүүс олон гээч” хэмээн тэрбээр өгүүлсэн юм.

Оддыг ивээн тэтгэх зах зээл ч цэцэглэж, зарим шилдэг жүжигчин зэрэг хэд хэдэн брэндтэй гэрээлдэг гэдэгтэй хэрэгцэн хэрэгцэн гадаад төрхөөс нь болоод Жастин Бибертэй зүйрлэх нь олонтоо, 27 настай залуу жүжигчин Лу Хань Star Wars, KFC, L’Oréal, Gap, Puma, Crest, Volkswagen-тай гэрээ байгуулжээ.

Сурталчилгаанд тоглох, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд пост байршуулах зэрэг амлалт бүхий кампанийн хүрээнд шилдэг одод 10-15 сая юанийн гэрээ байгуулдгийг ийм ажил эрхэлдэг хүмүүс тайлбарласан юм.

“Сүүлийн 10 жилд дээд зэрэглэлийн нэр алдартнуудын үнэ даруй хоёр гаруй дахин өслөө. Одоо кампанийн хүрээнд 10 сая юанийн хөлс авдаг жүжигчин олон. Weibo-д (хятад твиттер!) ганц пост тавих үнэ хэдэн зуун мянган юанийн үнэтэй” хэмээн Хятадын хувцас загварын блоггер Питер Шью өгүүллээ.

Европын хувцас загварын брэндүүд хятад оддыг хамтран

ажиллахад “хэт доогуурдана” гэж үздэг байсан үе түүх болсныг тэрбээр нэмж дурдав. Харин ч өрнөдийн одод олон нийтийн сүлжээнд цөөн дагагчтайгаасаа болоод Хятадын ивээн тэтгэх арвин ундаргаас хангалттай хувь хүртэж чадахгүй байгаа юм. Жишээ нь, Леонардо ДиКаприо ердөө 1.4 сая Weibo дагагчтай бол Лу Хань 42 сая дагагчтай.

“Weibo дагагчдаар нь үнэлэх юм бол өрнөдийн шилдэг жүжигчид хятад супер одуудад дөхөх ч үгүй”-г хөгжмийн Billboard компанийн Азийн салбарын тэргүүн Жонатан Сербин тайлбарлав. “Хүмүүсийн хайртай, үнэлгээ сайтай од болох гэвэл ядаж хэлээр нь ярьдаг байх хэрэгтэй” хэмээн тэрбээр анхааруулж байлаа.

Энэ онд Хятадын коммунист нам (ХКН) оддын нэр хүндийг суртал ухуулгадаа ашиглахаар оролдлоо. Гол үзвэр эхлэхээс өмнө “социалист үнэт зүйл”-ийг магтан дуулсан богино хэмжээний баримтат киног Жэки Чан зэрэг од байлцуулан гаргах зааварчилгааг эрх баригч нар Хятадын кино театруудад өгсөн юм.

Нийт Хятадад (Тайванийг оролцуулаад) орлогоороо тэргүүлж буй уран бүтээлч нар, юаниар		
Жэки Чан	Жүжигчин, найруулагч	330 сая
Фан Бинбин	Жүжигчин	300 сая
Жэй Чоу	Дуучин, жүжигчин	260 сая
Ян Ян	Жүжигчин	240 сая
Лу Хань	Жүжигчин, дуучин	210 сая
Ян Ми	Жүжигчин	200 сая
Эйнжелбэйби	Жүжигчин	200 сая
Жао Ли-Ин	Жүжигчин	190 сая
Лю Тао	Жүжигчин	180 сая
Крис Ву	Жүжигчин, дуучин	150 сая

Нийгэд нэр хүнд нь суларсан ч аварга мөнгө хүртсээр буй оддын цалинг бууруулах намын оролдлого амжилт муутай. Үүнтэй уялдан гол жүжигчдэд олгох цалинг нийт төсвийн 70 хувиас хэтрүүлэхийг Хятадын телевизийн үйлдвэрлэлийн холбоо өнгөрсөн сараас хориглов. Телевизийн өргөн нэвтрүүлгийн компаниуд алдартай жүжигчдийг гол хөзөр болгон ашиглахыг хатуу хориглож буйг тус улсын мэдээллийн гол

зохицуулах байгууллага энэ онд анхааруулсан.

Цалинтай холбоотой журмыг жишээ нь жүжигчний цалинг тасалбар борлуулалтын орлоготой нь холбох замаар аргалж болдгийг кино бүтээгч нар тайлбарлаж байв. “Кино нь үнэнхүү гүйлгээтэй 10 орчим жүжигчин л бий. Тогтсон журмыг аргалах арга ч мундахгүй” хэмээн Бээжинд байрладаг найруулагч өгүүллээ.



Эдийн засаг

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Монголд 79.1 сая ам.доллар олгоно



Монгол Улсын эдийн засгийн өсөлт энэ оны эцэс гэхэд 3.3 хувьд хүрнэ гэж ОУВС-гаас тооцсон юм.

Б.Ганбаяр / ЗГМ©

Бусад донор улс болон байгууллага ойрын хугацаанд санхүүжилт олгоно

Энэ сарын 15-нд АНУ-ын нийслэл Вашингтон хотноо хуралдсан Захирлуудын зөвлөлийн шийдвэрээр ОУВС-гаас гадна “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд санхүүжилт олгохоо амласан донор орнууд болон байгууллагууд ойрын

хугацаанд санхүүжилт олгож эхэлнэ гэж тус сангийн Монгол дахь суурин төлөөлөгч Нэйл Сакер хэлсэн байна. “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр” хэрэгжих гурван жилийн хугацаанд ОУВС-гаас Монгол Улсад нийт 430 гаруй сая ам.доллар олгохоор болсон. Уг санхүүжилтийг хөтөлбөрийн үр дүнг харгалзан, улирал тутамд олгох юм.

ОУВС-гийн албан ёсны цахим хуудсанд дурдсанаар Монгол Улсын эдийн засаг төлөөлснөөс илүү сайжирсан. Ялангуяа, төсөв, санхүүгийн тоон үзүүлэлтүүд сайжирч, зорилтот түвшинд хүрсэн болохыг онцолсон байна. Монгол Улсын эдийн засгийн

өсөлт энэ оны эцэс гэхэд 3.3 хувьд хүрнэ гэж тус сангаас тооцсон юм.

Улс төр тогтворгүй ч хөтөлбөрийн хэрэгжилт эерэг байгаа


ОУВС-гийн дэд тэргүүн Мицухиро Фурусава Монголд улс төрийн тогтворгүй байдал үүссэн ч хөтөлбөрийн хэрэгжилт эерэг байгааг тодотгожээ.

Мөн валютын ханш тогтворжсон нь гадаад санхүүжилтийн зардал буурах боломж олгож буй төдийгүй бодлого тодорхойлогчид төсвийн алдагдал бууруулж, өсөлтийн чанар сайжруулах бүтцийн шинэчлэл эхлүүлсэн болохыг тэмдэглэсэн байна.

2017 оны эцэс гэхэд төсвийн алдагдал ДНБ-ий 7.6 хувьтай тэнцэхээр байгаа. Энэ нь 2018 оны төсөв болон 2017 оны төсвийн тодотголтой нийцэж байгааг ОУВС-гаас онцолсон. Улс төрийн орчин тогтворгүй байгаа хэдий ч бодлого тодорхойлогчид дунд хугацаанд макро эдийн засгийн өсөлтийг хадгалж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, олон тулгуурт

хөгжлийн бодлогын дэмжих, өсөлт, уналтын мөчлөгийг багасгахад чиглэж байна гэж үзсэн байна.

Тэрчлэн татварын тогтолцоог бэхжүүлж, төсвийн сахилга батыг сайжруулахаар зорьж байгаа. Үүний зэрэгцээ зорилтот бүлэгт чиглэсэн халамжийн бодлого хэрэгжүүлж, хүүхдийн мөнгө олгож, хүнсний нэмэгдэл олгож байгааг тэмдэглэсэн. Гэхдээ ОУВС-гаас Монголын эдийн засаг дахь эрдэлүүдийг нэрлэсэн. Тодруулбал, Монголын эдийн засаг түүхий эдийн зах зээлээс хэт хамааралтай хэвээр байгаа болон өр төлбөрийн хэмжээ өндөр буйг анхааруулсан байна. [ЗГМ]



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

“Хөрөнгө оруулагч үндэстэн” нээлттэй компани боллоо

“Хөрөнгө оруулагч үндэстэн” хувьцаат компани “Жинст Увс” хувьцаат компанитай нэгдэж, нээлттэй хувьцаат компани боллоо. Тус компанийн арилжааны нээлт баасан гарагт болж, Монголын хөрөнгийн биржийн 5620 дахь арилжааг эхлүүлээ. Энэ үеэр хүндэтгэлийн цанг Монголын хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирал Х.Алтай, “Хөрөнгө оруулагч үндэстэн” компанийн ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг, тус компанийн гүйцэтгэх захирал Б.Тамир нар цохилоо. Ингэснээр 900 гаруй үндэсний хөрөнгө оруулагч иргэн, аж ахуйн нэгжийг эгнээндээ нэгтгэсэн “Хөрөнгө оруулагч үндэстэн” анх удаа урвуу нэгдэл

хэлцэл хийж, хөрөнгийн зах зээлд шинэ “бүтээгдэхүүн”-ий тоог нэгээр нэмэв. Хөрөнгө оруулагч үндэстэн” компанийн гүйцэтгэх захирал Б.Тамир “Манай компани өдгөө “Ард санхүүгийн нэгдэл”-ийн долоо орчим хувийг эзэмшдэг бөгөөд компанийнхаа нэгж хувьцааны доод үнэлгээг хоёр жил хүрэхгүй хугацаанд 60 гаруй хувиар өсгөсөн үр дүнг гаргалаа” хэмээн тодотгов. Харин Санхүүгийн зохицуулах хорооны дарга С.Даваасүрэн “Хоёр компанийн нэгдэл хөрөнгийн зах зээлд шинэ жишиг тогтоож байна. Энэ үйл явц эдийн засгийн өгөөж, баялгийг зохистой хуваарилахад чухал үр дүнтэй” хэмээн онцоллоо. [ЗГМ]

ИМПОРТ

Шатахууны импорт 32 хувиар өсөв

Автобензины импорт энэ оны арваннэгдүгээр сарын байдлаар 227.1 сая ам.доллар болж, жилийн өмнөхөөс 32 хувиар өссөнийг Үндэсний статистикийн хороо мэдээллээ. Дизелийн түлшний импорт 75.8 хувиар өсөж, 385.5 сая ам.доллар болсон байна. Энэ онд нүүрсний зах зээл сэргэснээс тээврийн эргэлт нэмэгдсэн, эдийн засгийн идэвх сэргэсэн. Үүнээс

гадна ОУВС-гийн хөтөлбөрийн хүрээнд шатахууны онцгой албан татварыг үе шаттай нэмэхээр болсон. Эдгээр шалтгааны улмаас дотоодын эрэлт өндөр байсныг салбарынхан онцолж байна. Шатахуун импортлогч компаниуд сүүлийн хоёр сард шатахуунаа хангалттай сайн нөөцөлсөн гэдгийг Ашигт малтмал, газрын тосны газраас мэдээллээ.

УУЛ УУРХАЙ

Нүүрс олборлогчдын хувьцааны ханш буурлаа

Монгол Улс өнгөрсөн сарын байдлаар 31.3 сая тонн нүүрс экспортлсон нь өнгөрсөн оны мөн үеэс 40 гаруй хувиар өссөн дүн юм. Гэхдээ өнгөрсөн долдугаар сараас Гашуунсухайт-Ганцмодны боомтоор нүүрс нэвтрүүлэх хэмжээг бууруулсан нь салбарын компаниудад сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал, Хонконгийн хөрөнгийн биржид бүртгэлтэй Mongolian Mining Corporation-ийн хувьцааны ханш буурах хандлагатай байна. Хувьцааны ханш наймдугаар сард 0.33 хонконг долларт хүрч байсан бол түүнээс хойш буурсаар 0.19 хонконг доллар болжээ. Өөрөөр хэлбэл, Тавантолгойн уурхайн аман дахь нүүрсний ачилтыг нь

зогсоосны дараа хувьцааны ханш нь 1.53 хувиар буурч, 0.19 хонконг доллар боллоо. Хөшөөтийн уурхайд олборлолт хийж буй Mongolia Energy Corporation-ийн хувьцааны ханш жилийн өмнө 0.31 хонконг доллар байсан бол одоо 0.19 хонконг доллар болсон байна. Түүнчлэн Торонтогийн хөрөнгийн биржид Southgobi Resources-ийн хувьцааны ханш өнгөрсөн хоёрдугаар сард 0.46 канад доллар болсон нь сүүлийн нэг жил дэх хамгийн өндөр үзүүлэлт. Харин өнгөрсөн долоо хоногийн байдлаар тус компанийн хувьцаа 0.18 канад доллараар үнэлэгдэж байна. Тус компани Овооттолгойгоос олборлолт хийж байгаа юм. Мөн Улаан-Овоогийн ордод

олборлолт хийж буй Prophecy Development-ийн нэгж хувьцааны ханш Торонтод өнгөрсөн нэгдүгээр сард 6.65 канад доллар байсан бол энэ долоо хоногт 4.26 канад доллартай тэнцэж байна. Баруун Ноён уул ордоос олборлолт хийдэг Tetgasom компани Австралийн хөрөнгийн биржид мөн буурч, 0.18 австрали доллар болжээ.

Монгол Улсын Засгийн газрын 320 дугаар тогтоолоор Тавантолгойн бүлэг ордын экспортын нүүрсний ачилтыг энэ сарын 12-ны 00 цагаас эхлэн түр хугацаагаар зогсоожээ. Манай улсын нүүрсний экспортын гол гарц болох Гашуунсухайт-Ганцмодны боомтод үүссэн гацаа буурах хүртэл энэ арга хэмжээг авах аж.

ТАТВАР

ХХОАТ-ын шинэ шатлал төсвийг дэмжихгүй

Б.Дашням Шинжээч

СЭЗИС-ийн судалгаагаар ирэх онд шатлал тогтоох хувь хүний орлогын албан татварыг (ХХОАТ) үндэслэлгүй, төсвийн орлогыг нэмэгдүүлэх боломжгүй шинэчлэлт гэж дүгнэсэн байна. Иргэдэд татвар төлөх сэтгэлгээ

төлөвшөөгүй, татвараас зайлсхийх хандлага өндөр тул нийгмийн даатгалын шимтгэл болон хувь хүний орлогын албан татвар буурах төлөвтэй. Мөн шатлалын интервал хэт ойр буюу нэг сая хүртэлх төгрөг тул 400 орчим ам.долларын зөрүүгээс хамаарч таван хувийн ялгаатай татвар төлөхөөр тусгасныг шүүмжилжээ. Түүнчлэн ам бүлийн гишүүдийн

тоо болон бусад хүчин зүйлийн нөлөөллийг харгалзан үзээгүй. Тодруулбал, тэжээлгэгч иргэдийн тоо үүнд хамааралтай байх ёстой. Хөдөлмөрийн бүтээмж, мэдлэг ур чадвар, илүү цагаар хөдөлмөрлөх гэх мэт хүчин зүйлсийг бодолцоогүй, цалингаас бусад төрлийн орлогоос татвар авах тухай тусгаагүй зэрэг дутагдал илэрчээ.

ЗГМ ТОВЧХОН

» ТҮҮХИЙ ЭД

0.4

Хувь. West Texas төрлийн газрын тосны ханш 0.4 хувиар дээшилж, баррель нь 57.29 ам.доллартай тэнцэв.

» УУЛ УУРХАЙ

0.3

Хувь. Алтны ханш 0.3 хувиар чангарч, 1256.74 ам.долларт хүрлээ.

2

Хувь. Зэсийн ханш Нью-Йоркид хоёр хувиар өсөж, фунт нь 3.11 ам.долларт хүрэв.

» ХӨРӨНГИЙН БИРЖ

180

Мянга. Монголын хөрөнгийн биржийн энэ сарын 15-ны арилжаагаар 29 хувьцаат компанийн 180 мянган ширхэг хувьцаа арилжлаа. Үүнээс 13 хувьцааны ханш өсөж, 16 нь ханш буурсан байна.

» ХУВЬЦАА

15

Хувь. “Е-Моние”, “Хөвсгөл Усан зам” компанийн хувьцааны ханш хамгийн өндөр буюу 15 хувиар өссөн бол “УБ-Бүк” компанийн хувьцааны ханш 4.44 хувиар уналаа.

» ҮНЭТ ЦААС

6.7

Сая төгрөг. Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар 67 ширхэг үнэт цаас 6.7 сая төгрөгөөр арилжлаа.

» ИНДЕКС

0.9

Хувь. MSE ALL индекс 1,166.71 нэгж болж 0.9 хувиар буурлаа.

1.2

Хувь. Америкийн хөрөнгийн зах зээлийн S&P 500 индекс 0.9 хувиар өссөн бол Nasdaq 100 индекс 1.2 хувиар дээшлэв.

» САНХҮҮ

0.4

Хувь. Bloomberg-ээс тооцдог ам.долларын спот индекс 0.4 хувиар өслөө.

» ДЭЛХИЙД

25

Хувь. 400 тэрбум ам.доллараар үнэлэгдэх тансаг зах зээлийн 10 хувийг онлайн худалдаа эзэлдэг аж. Гэхдээ 2025 он гэхэд энэ тоо 25 хувь болж өсөх боломжтой гэж зөвлөх үйлчилгээний “Bain” компани тооцжээ.

ВАЛЮТЫН ХАНШ

Ам.доллар	2,434.22
Евро	2,870.55
Япон иен	21.71
ОХУ рубль	41.33
БНХАУ юань	368.44
БНСУ вон	2.23

Сурталчилгаа



БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ГРАНПРИ 2009/2012/2014/2015

*** *Та бүхэнд шинэ оны мэнд хүргэе!* ***

БИДНИЙ ТУХАЙ

“АБСОЛЮТ” төв нь 2001 онд БСШУЯ-ны тусгай зөвшөөрөлтэй байгуулагдсан цагаасаа Монголын мянга мянган залуусын англи хэлний боловсролд оорийн хувь нэмрийг дорвитой оруулан бусдыгаа чанараараа дагуулсаар ирлээ. Энэ хугацаанд 30000 гаруй оюутан залуус манайд суралцаж төгссөн юм. Бид англи хэлний бүх шатнаас TOEFL, IELTS-ийн түвшинг дүүргэтэл өөрийн оюутнуудаа бэлтгэн төгсөгчид маань шалгалтандаа жигд өндөр оноо авч жил бүр рекорд амжилт шинэчлэн тогтоож, тэтгэлгээр суралцах ямар ч шалгалтанд заавал тэнцдэг. Манай ажлын үр дүн суралцагчдын маань гаргасан амжилтаар хэмжигдэж энэ хугацаанд 1000 гаруй оюутан залуус дэлхийн топ сургуулиудад Засгийн газар хоорондын, сангуудын, тухайн сургуулиудын гэх мэт тэтгэлгээгүүдэд хамрагдаж суралцаж чадлаа. Одоо тэд маань эх орондоо эргэн ирж тухайн салбартаа манлайлагч болж ажиллаж эх орны хөгжилд хувь нэмрээ оруулж байгаа нь бидний бахархал юм.

ДАВУУ ТАЛ

- ✓ Суралцагчид нь TOEFL, IELTS-ийн шалгалтуудад хамгийн өндөр оноог авдаг.
- ✓ Сонгоол, ярианы чадвар сайжруулах хичээлүүдийг англи, америк багш нар, олон улсын TESOL зэрэгтэй гадаад багш нар 100% заадаг.
- ✓ Англи хэлний бүх шатны түвшингээс TOEFL, IELTS-ийн шалгалтуудад хамгийн шилдэг тусгай хөтөлбөрөөр бэлтгэж өгдөг.
- ✓ TOEFL, IELTS-ийн хамгийн сүүлийн үеийн шилдэг сурах бичгүүдийг сургалтандаа ашигладаг.
- ✓ Ням гараг бүр TOEFL, IELTS-ийн загвар тест, гадаад үг чээжлэх цуврал хичээлүүд явагддаг.
- ✓ 7 хоног бүр 100% гадаад багштай ярианы клуб, бүх шатны дүрмийн хоцрогдол арилгах нэмэлт давтлага хичээлүүдийг үнэ төлбөргүй явуулдаг.
- ✓ АНУ-д хэл шинжлэлийн чиглэлээр магистр, Англид бакалавр хамгаалсан, АНУ-д мэргэжил дээшлүүлсэн олон улсын TEFL зэрэгтэй монгол багш нар, АБСОЛЮТ төвийн үндсэн гадаад багш нарын хүчирхэг баг хичээлийг заадаг.

СУРГАЛТЫН ТӨРӨЛ

- ✓ TOEFL iBT, IELTS-ийн шалгалтанд бэлтгэх сургалтууд
- ✓ Цаашид гадаадад тэтгэлгээр суралцах хүсэл зорилготой хүүхэд залуусыг англи хэлний анхан, дунд шатнаас эхлэн TOEFL iBT, IELTS-ийн шалгалтад тусгай хөтөлбөрөөр бэлтгэх сургалтууд
- ✓ Байгууллагын захиалгат сургалт
- ✓ VIP ганцаарчилсан сургалт
- ✓ 100% гадаад багштай яриа дүрэм хосолсон сургалтуудыг тогтмол хичээллүүлж байна.

АБСОЛЮТ-Н АМЖИЛТЫН ХЭСГЭЭС ...



АБСОЛЮТ-н төгсөгч **Ө.ЭНХЖИН**
IELTS 8.0 оноо
Nagoya University
100% тэтгэлэг



АБСОЛЮТ-н төгсөгч **Б.БИЛГҮҮН**
TOEFL iBT 117 оноо
University of California
100% тэтгэлэг



АБСОЛЮТ-н төгсөгч **П.АРИШНАА**
IELTS 8.0 оноо
Nagoya University
100% тэтгэлэг



АБСОЛЮТ-н төгсөгч **Г.ЦЭВЭЭНДОРЖ**
TOEFL iBT 110 оноо



АБСОЛЮТ-н төгсөгч **Г.ТОГСБИЛЭГ**
IELTS 8.0 оноо



АБСОЛЮТ-н төгсөгч **Т.ДЭЛГЭРМАА**
IELTS 7.0 оноо
Швейцарь.



АБСОЛЮТ-н төгсөгч **Э.БУЖИНЛХАМ**
TOEFL iBT 108 оноо



АБСОЛЮТ-н төгсөгч **А.ЭРТЭНЭ-ОЧИР**
IELTS 7.5 оноо



АБСОЛЮТ-н төгсөгч **Б.ЦЭНГҮҮНЖАВ**
IELTS 7.0 оноо
Cornell University
Fulbright 100% тэтгэлэг



АБСОЛЮТ-н төгсөгч **Б.БАТЭМҮҮЛЭН**
TOEFL iBT 105 оноо
МУ Засгийн Газрын 100% тэтгэлэг,
University of Washington



АБСОЛЮТ-н төгсөгч **В.ЯНЖИНЛХАМ**
IELTS 7.5 оноо
DAAD Герман
100% тэтгэлэг



АБСОЛЮТ-н төгсөгч **Ю.ОНОБОЛД**
IELTS 7.5 оноо



АБСОЛЮТ-н төгсөгч **А.БИЛГҮҮН**
Niaiyin Institute of Technology
100% тэтгэлэг



АБСОЛЮТ-н төгсөгч **З.ОЧИР-ЭРДЭНЭ**
IELTS 7.5 оноо



АБСОЛЮТ-н төгсөгч **Б.БАЙГАЛЬ**
TOEFL iBT 105 оноо
Хятадын Засгийн Газрын
100% тэтгэлэг,
Nanjing Forestry University



АБСОЛЮТ-н төгсөгч **С.ДОЛГООН**
IELTS 7.0 оноо



АБСОЛЮТ-н төгсөгч **Н.ТЭРГЭЛ**
University of British Columbia



АБСОЛЮТ-н төгсөгч **Э.САРУУЛЗАЯА**
IELTS 7.0 оноо
Тайваний Засгийн Газрын
100% тэтгэлэг



АБСОЛЮТ-н төгсөгч **Э.ОДБАЯР**
Унгарын Засгийн Газрын
100% тэтгэлэг
University of Debrecen



АБСОЛЮТ-н төгсөгч **О.ЧИНСАНЧИР**
IELTS 7.5 оноо



АБСОЛЮТ-н төгсөгч **You Saf Gill JULIA**
IELTS 7.0 оноо
University of Victoria



АБСОЛЮТ-н төгсөгч **Б.АНХЧИМЭГ**
IELTS 7.5 оноо



АБСОЛЮТ-н төгсөгч **ШЕРКЕНУР**
American University in Bulgaria
100% тэтгэлэг



АБСОЛЮТ-н төгсөгч **Б.ДӨЛГӨӨН**
IELTS 7.0 оноо



АБСОЛЮТ-н төгсөгч **Ц.НОМИН**
IELTS 7.0 оноо



ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

2017 ОНЫ ТОЙМ

“Засгийн газрын мэдээ” сонин энэ онд дотоодын улс төр болон эдийн засгийн ертөнцөд өрнөсөн онцлох үйл явдлуудыг нэрлэж байна. Улс төрийн амьдралыг талцал хуваагдал, тогтворгүй байдал, уналт, хямрал гэсэн үг илэрхийлж байгаа бол эдийн засгийн нөхцөл байдлыг хямрал, хүндрэл, сэргэлт хэмээн тодорхойлж болно. Учир нь, Монгол Улсын тав дахь Ерөнхийлөгчийг сонгосон сонгуулийн дүн УИХ-д үнэмлэхүй олонхийг бүрдүүлж буй эрх баригч хүчинд талцал хуваагдал бий болгосон. Улмаар 65 суудалтай МАН Ж.Эрдэнэбатын Засгийн газрыг огцруулж, У.Хүрэлсүхэд гүйцэтгэх засаглалыг удирдах боломж олгов. Улс төрийн орчинд үүссэн энэхүү тогтворгүй байдал, Ерөнхийлөгчийн сонгууль угтсан зарим уршигтай алхам эдийн засагт тусгалаа олж, хөрөнгө оруулалтын орчныг улам дордуулсан тал бий. Энэ нь уул уурхайн салбарт, тодруулбал, хүлээгдэж буй мега төслүүдийн ирээдүйг улам бүрхэг болгож орхисон юм. “Тавантолгой”, “Гачуурт” тэргүүтэй төслийн хөрөнгө оруулалтын хэлцэл гацаж, харин “Оюутолгой” төслийн далд уурхайн бүтээн байгуулалт эрчимжив. Дефляц нүүрлэсэн эдийн засагт инфляц эргэн ирж, ам.доллартай харьцах төгрөгийн ханш тогтворжиж, ОУВС-д төсөв, мөнгөний бодлогын жолоо, цулбуураа даатгалаа. Нүүрсний экспорт түүхэн дээд хэмжээнд хүрч, төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнээс давж биелэв. Нийгмийн захиалга болсон ипотекийн зээл саармагжиж, хөрөнгийн зах зээл сэргэв. Дотоодын компаниудын нэгдэн нийлэх үйл явц идэвхжиж, Монголын хөрөнгийн биржээр дамжуулан компаниуд хөрөнгө босгох хандлага цар хүрээгээ тэллээ. Татварын хувь хэмжээ нэмэгдэж, хувийн хэвшил болон иргэдэд ирэх дарамт нэмэгдлээ. ДНБ 5.8 хувиар өсөж, гэгээтэй үзүүлэлт тодрох болов. Хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт хүндхэн жил байлаа. Учир нь, нийт нутгаар хур бороо бага орсны улмаас гандуу, ургац тааруу байв. Мөн өвс тэжээлийн гарц муудаж, аймаг, сум дамжсан отор нүүдэл урьд жилүүдтэй харьцуулахад нэмэгдсэн юм. Энэ нь, хөдөө аж ахуйн салбарын эдийн засагт үзүүлэх үр нөлөөг багасгав.



ТАЛЦАЛ ХУВААГДАЛ, ХҮНДРЭЛ СЭРГЭЛТ

УЛС ТӨР # 1

Дахин санал хураалтаар сонгогдсон Ерөнхийлөгч

Монгол Улс ардчилсан Үндсэн хуулийг баталж, Ерөнхийлөгчийг бүх ард түмнээсээ сонгодог болоод нийт долоон удаагийн ээлжит сонгуулийг хийсэн. Энэ дундаа долоо дахь удаагийн Ерөнхийлөгчийн сонгуулийн ялагч түүхэндээ анх удаа дахин санал хураалтаар /2017.07.07/ тодорсон нь 2017 оны онцлох үйл явдлын нэг болж байна. 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуульд Ардчилсан намаас нэр дэвшигч Х.Баттулга 50.7 хувь буюу нийт 595275 хүний саналаар ялалт байгуулсан юм. Тэгвэл МАН-аас нэр дэвшигч М.Энхболд 482092 хүний санал авсан байв. Харин эхний санал хураалтад нэр дэвшигчдийн авсан саналыг жагсаавал Х.Баттулга 517.478 санал буюу 38.11 хувь, М.Энхболд 411.748 санал буюу 30.32 хувийн санал авсан байсан юм. Мөн МАХН-аас нэр дэвшигч С.Ганбаатар 409.899 санал буюу 30.19 хувийн дэмжлэг тус тус авснаар хэн нь ч олонхын саналыг авч чадаагүй юм.

▶15

ЭДИЙН ЗАСАГ # 1

“Гэрэгэ” бонд гаргав

Монгол Улсын Засгийн газар олон улсын зах зээл дээр “Гэрэгэ” бонд гаргаж, 5.5 жилийн хугацаатай, 800 сая ам.доллар босголоо. 5.625 хувийн хүүтэй гаргасан нь сүүлийн жилүүдийн хамгийн доод түвшин байв. “Гэрэгэ” бондын санхүүжилтээр манай улс он гарангуут “Чингис” бондын 500 сая ам.доллар болон зургадугаар сарын эцэст “Дим сам” бондын 160 сая ам.долларын өр, төлбөр барагдуулах юм. “Гэрэгэ” бондыг худалдан авах 5.5 тэрбум ам.долларын захиалга хөрөнгө оруулагчид ирүүлсэн бөгөөд бондын дийлэнх буюу 77 хувийг нь хөрөнгийн удирдлагын компаниуд худалдан авчээ. Энэ нь хөрөнгө оруулагчид манай улсад итгэж буйн нэг илрэл. Үүний үр дүнд 2021 он хүртэл бондын төлбөрөөс үүдэлтэй дефолтын эрсдэлээс сэргийлэх нөхцөл бүрдсэн юм. “Гэрэгэ” бондын хувьд эрэлт өндөр байсан тул 800 сая ам.долларыг төлөвлөж байснаас бага хүүтэй босгож чадсан.

▶16

Засгийн газрын мэдээ сонины 2018 оны I улирлын захиалга эхэллээ

Улиралд: 30,000₮ (63 дугаар)

Хагас жилд: 60,000₮ (127 дугаар)

Бүтэн жилд: 120,000₮ (254 дугаар)

Нэмэлт захиалга: 21,000₮ (42 дугаар)

Утас: 7010 3131, 9990 3581

tdbpay үйлчилгээгээр цахим сонин худалдан авах



Та энэхүү QR кодыг уншуулан гүйлгээний утга хэсэгт өөрийн и-мэйл хаяг, утасны дугаараа бүртгүүлэн дижитал сонинг захиална уу?

Таны эрх ажлын 8 цагийн дотор идэвхжих болно.

UBinfo.mn

Соёлт хүний өглөө сонин уншихаас эхэлдэг

Сурталчилгаа

ЭРХЭМ ЗАХИАЛАГЧ ТА “МОНГОЛ ШУУДАН” КОМПАНИД ХЭВЛЭЛЭЭ ЗАХИАЛНА УУ! 2018 ОНЫ I УЛИРЛЫН ХЭВЛЭЛ ЗАХИАЛГА СУМДАД 12 ДУГААР САРЫН 25-НЫГ ХҮРТЭЛ, УЛААНБААТАР ХОТ БОЛОН АЙМГИЙН ТӨВҮҮДЭД 12 ДУГААР САРЫН 29-НИЙГ ХҮРТЭЛ, НЭМЭЛТ ЗАХИАЛГА НЭГДҮГЭЭР САРЫН 29-НИЙГ ХҮРТЭЛ ЯВАГДАНА.

Хэвлэл захиалгын мөнгийг Улаанбаатар хотод “Монгол Шуудан” Төрийн банкны 100000139702 тоот дансанд, бусад аймаг, хот, сум, суурин газруудад тус тусын банкны салбар дахь тухайн аймгийн шуудангийн газрын хэвлэлийн харилцах дансанд тушаага холбогдох тооцоог хийнэ.

“МОНГОЛ ШУУДАН” ХК
УТАС / ФАКС: 7007 8916, 7007 8900, ШУУДАН ЛАВЛАХ: 1800-1613

ДАРААХ ХЭВЛЭЛЭҮД РЕДАКЦИАС ГАРААГУЙ ТУЛ БУЦААН ТООЦОО ХИЙНЭ ҮҮ!

№	ИНДЕКС	ХЭВЛЭЛИЙН НЭР	Хагас жил		Умар		Нэмэлт	
			Дугаар	Үнэ	Дугаар	Үнэ	Дугаар	Үнэ
1	10035	БҮГДЭС ТАЙМС						
2	10386	УЛААН ОДХОН						
3	20026	ГАДААД ХЭВЛЭХ АРГА УВИН АСУУДАЛ						
4	20045	НЬМАХ САРГАЛ						
5	20104	БАРИДА ХОЖИЛ						
6	20704	ДАВАН						
7	22811	ГРАНД						

1. ӨДӨР ТУТМЫН СӨНИН

Индекс	ХЭВЛЭЛИЙН НЭР	Хагас жил		Умар		Нэмэлт	
		Дугаар	Үнэ	Дугаар	Үнэ	Дугаар	Үнэ
102108	ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ +Financial Times	128	60000	64	30000	44	21000
100774	ТҮҮЭНЫ МЭДЭЭ	130	35000	65	17500	43	12000
100757	МОНГОЛЫН МЭДЭЭ	128	44000	64	22000	44	10000
100004	МОНГОЛЫН ҮНЭН	122	30000	61	15000	41	10000
101545	ӨГЛӨӨНИЙ СӨНИН	120	40000	60	20000	40	17000
100816	ӨӨРИЙН СӨНИН	128-132	45200	64-66	22600	44	16300
100518	ӨНӨНДӨР	128-132	48000	64-66	24000	44	16500
101512	ӨНӨНДӨР + IВ POST	204	185000	66-68	92500	44-26	60200
101606	УИДЭХНИЙ ШУУДАН (гууны шуудан)	128	40000	64	20000	44	14000

2. ГУРАВ ХОНОГ ТУТМЫН СӨНИН

Индекс	ХЭВЛЭЛИЙН НЭР	Хагас жил		Умар		Нэмэлт	
		Дугаар	Үнэ	Дугаар	Үнэ	Дугаар	Үнэ
194058	НИЙМНИЙ ШУУДАН	50	36000	25	18000	16	15000
100673	ШУУРХАЙ ЗАР сарын шуудангаар хүргэгдэнэ!	48	60000	24	34500	18	25500
100501	ЗАР МЭДЭЭ СҮРТАЛЧИЛГА сарын шуудангаар хүргэгдэнэ!	44	66000	22	33000	14	21000
100537	IВ POST Online, 12 нур, англи хэлээр	72	140900	36	68900	26	43700

3. ДОЛОО ХОНОГ ТУТМЫН СӨНИН

Индекс	ХЭВЛЭЛИЙН НЭР	Хагас жил		Умар		Нэмэлт	
		Дугаар	Үнэ	Дугаар	Үнэ	Дугаар	Үнэ
114876	УЛС ТӨРИЙН ТӨЙМ	24	18000	12	9000	8	6000
105102	УЛС ТӨРИЙН СӨНИН	24	24000	12	12000	8	8000
100829	ТАЛ ДАМ	26	13000	13	6500	9	4800
101268	МОНГОЛ ШУУН	26	24000	13	12000	9	9000
100070	MONGOL MESSENGER (МОНГОЛ ЭГЭР)	26	24000	13	12000	9	9000
100702	МОНГОЛЫН МЭДЭЭ (Хөвд хэлээр)	26	24000	13	12000	9	9000
100184	НОВОСТЫ МОНГОЛЫН	26	24000	13	12000	9	9000
101119	OPEN BOOK ХӨГЖЭЛТЭЙ ХААГАЛ	24	24000	12	14000	8	10000
100018	СОЕМБО	26	10000	13	5000	9	3000
100459	СЭРҮҮЛЭГ	24	12000	12	6000	8	5000
103001	СОЛОНГО	24	УНГЯ УГИ	12	УНГЯ УГИ	8	УНГЯ УГИ
100011	ХӨДӨМӨР	24	12000	12	6000	8	4800
100178	ХУУМУЙН БИЙН	24	6000	12	3000	8	2500

4. АРАВ ХОНОГ ТУТМЫН СӨНИН

Индекс	ХЭВЛЭЛИЙН НЭР	Хагас жил		Умар		Нэмэлт	
		Дугаар	Үнэ	Дугаар	Үнэ	Дугаар	Үнэ
107027	АРЧИДАЛ ТАЙМС	18	12000	9	6000	6	5000
100752	БОЛСОН ВЯДАЛ	18	27000	9	13500	6	9000
100161	ВЭХ	12	9600	6	4800	4	3200
101735	МОНГОЛЫН АМЬДРАЛ	18	12000	9	6000	6	5000
100013	МОНГОЛЫН ХӨДӨМӨР	12	12000	6	6000	4	4000
100645	НӨЦӨЙ МЭДЭЭ	18	27000	9	13500	6	9000
101478	ОДОО ЦАГ	12	12000	6	6000	3	3300
100912	САНХҮҮНИЙ МЭДЭЭ	18	10800	9	5400	6	3600
100012	УТГА ХӨДӨЛ, УРАГ	18	11000	9	5500	6	4000
100474	УНИЙН МЭДЭЭ	20	16000	10	8000	6	4800
159918	ХОРХОТГОЙ БҮС	14	15400	7	7700	4	4400
100229	ХОХ ТОЛВО	18	9000	9	4500	6	3000
101665	ЭХ ОРНЫ МАНАА	18	10000	9	5000	6	3500

5. АРВАН ДӨРӨВ ХОНОГ ТУТМЫН СӨНИН

Индекс	ХЭВЛЭЛИЙН НЭР	Хагас жил		Умар		Нэмэлт	
		Дугаар	Үнэ	Дугаар	Үнэ	Дугаар	Үнэ
100164	АМЬДРАХ УХААН	12	9600	6	4800	4	3200
100624	АНАГААХ АРГА БИЛИГ	12	19200	6	9600	4	6000
100625	АНАГААХ АРГА БИЛИГ (2015 ОНЫ ХУУЧИН ДУГААРУУДАЛ)	1	28800	-	-	-	-
101560	ДАЛД АМЬДРАЛ	12	16000	6	8000	4	5400
103089	ЗАЛУУ НАС	12	12000	6	6000	4	4000
100001	МЭРГЭЖИСНИЙ НИГТЛАН БОДОГЧ	12	10800	6	5400	4	3600
109910	ӨНЦӨЙ МЭДЭЭ	12	9000	6	4500	4	3000
163451	ЭРҮҮЛ МЭДИЙН ЖОР	10	15000	5	7500	3	4500

6. САР ТУТМЫН СӨНИН

Индекс	ХЭВЛЭЛИЙН НЭР	Хагас жил		Умар		Нэмэлт	
		Дугаар	Үнэ	Дугаар	Үнэ	Дугаар	Үнэ
101081	БАГШ	6	12000	3	6000	2	4000
100548	БИЛГИЙН МЭДИЙН	6	3000	3	1500	2	1000
115457	ГЕОЛОГИ УУЛ УУРХАЙН МЭДЭЭ	6	6000	3	3000	2	2000
100520	ДАЛ Зөгөөд сонин, Өнгөрөөс, олоо, ирэхгүйн эн сонин, танин хэлээр	2	2000	1	1000	1	1000
100021	МОНГОЛЖИГОО	6	2700	3	1350	2	900
107660	Математи 1-3 анги	6	15000	3	7500	3	7500
107661	Математи 4-5 анги	6	15000	3	7500	3	7500
107662	Математи 6-9 анги	6	15000	3	7500	3	7500
107663	Математи 10-12 анги	6	15000	3	7500	3	7500
100873	НЭГЭЛТЭЙ СҮРТҮҮЛЭГ	6	3600	3	1800	2	1200
101001	ОЮУНД ТУССАН ГЭГЭЭ	6	6000	3	3000	2	2000
101227	УЛАМЖАЛТ АНАГААХ УХААН СӨНИН	6	6000	3	3000	3	3000
101409	ХОДОО АЖ АХУЙН МАРГААШ	6	3000	3	1500	2	1000
101539	СУРАГЧИЙН ЕРТӨНЦ	6	10000	3	5000	2	3500
101016	СЭНГЭЛ ЗҮЙН	4	10800	2	5400	2	5400
106158	ТАНЫ АМЬДРАЛ	6	6000	3	3000	2	2000
100651	НЭХ /хуулийн танин мэдэхүйн сонин бүх нур өнгөрөөс/	6	10000	3	5000	2	3400
101655	Шамбалын гэрэл (2009 оны 12 дугаар)	2	30000	1	15000	1	15000
1102701	"Математикийн Цэг" I анги Хавсралт дугаар "Өөрийн үнэлгээ 1-р анги" хөдөр дэлгэр хэргэлдэг	Үндсэн 3 + хавсралт 1				5900	
1102702	"Математикийн Цэг" II анги Хавсралт дугаар "Өөрийн үнэлгээ 2-р анги" хөдөр дэлгэр хэргэлдэг	Үндсэн 3 + хавсралт 1				5900	
1102703	"Математикийн Цэг" III анги Хавсралт дугаар "Өөрийн үнэлгээ 3-р анги" хөдөр дэлгэр хэргэлдэг	Үндсэн 3 + хавсралт 1				5900	Захиачан бүрт "Математикийн Цэг IV анги" сонин өргөдөл өгөх бөгөөд эцэс бүрт хэргэлдэг хавсралт дугаарыг хэргэлдэг.
1102704	"Математикийн Цэг" IV анги Хавсралт дугаар "Өөрийн үнэлгээ 4-р анги" хөдөр дэлгэр хэргэлдэг	Үндсэн 3 + хавсралт 1				5900	Хавсралт дугаарыг хэргэлдэг дугаарыг сонинтой хамт хэргүүлнэ.
1102705	"Математикийн Цэг" V анги Хавсралт дугаар "Өөрийн үнэлгээ 5-р анги" хөдөр дэлгэр хэргэлдэг	Үндсэн 3 + хавсралт 1				5900	
1102706	"Математикийн Цэг" VI анги Хавсралт дугаар "Өөрийн үнэлгээ 6-р анги" хөдөр дэлгэр хэргэлдэг	Үндсэн 3 + хавсралт 1				5900	
1102707	"Математикийн Цэг" VII анги Хавсралт дугаар "Өөрийн үнэлгээ 7-р анги" хөдөр дэлгэр хэргэлдэг	Үндсэн 3 + хавсралт 1				5900	
1102708	"Математикийн Цэг" VIII анги Хавсралт дугаар "Өөрийн үнэлгээ 8-р анги" хөдөр дэлгэр хэргэлдэг	Үндсэн 3 + хавсралт 1				5900	
1102709	"Математикийн Цэг" IX анги Хавсралт дугаар "Өөрийн үнэлгээ 9-р анги" хөдөр дэлгэр хэргэлдэг	Үндсэн 3 + хавсралт 1				5900	
1102710	"Математикийн Цэг" X анги Хавсралт дугаар "Өөрийн үнэлгээ 10-р анги" хөдөр дэлгэр хэргэлдэг	Үндсэн 3 + хавсралт 1				5900	
1102711	"Математикийн Цэг" XI анги Хавсралт дугаар "Өөрийн үнэлгээ 11-р анги" хөдөр дэлгэр хэргэлдэг	Үндсэн 3 + хавсралт 1				5900	
1102712	"Математикийн Цэг" XII анги Хавсралт дугаар "Өөрийн үнэлгээ 12-р анги" хөдөр дэлгэр хэргэлдэг	Үндсэн 3 + хавсралт 1				5900	
1102714	Математикийн ахсын дугаар 2-р анги	1	4300				2017-2018 оны математикийн ахсын дугаарын нийгэмлэг болонгуудын хамт
1102715	Математикийн ахсын дугаар 3-р анги	1	4300				
1102716	Математикийн ахсын дугаар 4-р анги	1	4300				Тухайн ангид математикийн ахсын дугаарын нийгэмлэг болонгуудын хамт
1102717	Математикийн ахсын дугаар 5-р анги	1	4300				
1102718	Математикийн ахсын дугаар 6-р анги	1	4300				
1102719	Математикийн ахсын дугаар 7-р анги	1	4300				
1102720	Математикийн ахсын дугаар 8-р анги	1	4300				
1102721	Математикийн ахсын дугаар 9-р анги	1	4300				
1102722	Математикийн ахсын дугаар 10-р анги	1	4300				
1102723	Математикийн ахсын дугаар 11-р анги	1	4300				
1102724	Математикийн ахсын дугаар 12-р анги	1	4300				

7. УЛИРАЛ ТУТМЫН СӨНИН

Индекс	ХЭВЛЭЛИЙН НЭР	Хагас жил		Умар		Нэмэлт	
		Дугаар	Үнэ	Дугаар	Үнэ	Дугаар	Үнэ
109073	ЭМЭГТЭЙН ҮҮДИЙН ИШДЭР СӨНИН	2	3000	1	1500	1	1500

8. ОРОН НУТГИЙН ХЭВЛЭЛ

Индекс	ХЭВЛЭЛИЙН НЭР	Хагас жил		Умар		Нэмэлт	
		Дугаар	Үнэ	Дугаар	Үнэ	Дугаар	Үнэ
101239	АРХАНГАЙН АМЬДРАЛ (Архангай)	24	12000	12	6000	8	4000
101212	ЖАНА ДАУНР (Баян-Өлгий)	18	9000	9	4500	6	3000
101174	БАЯ						

Улс төр

2

Сунгаагаар тодорсон намын дарга



2016 оны УИХ-ын сонгуульд ялагдал хүлээсэн Ардчилсан нам удирдлагуудаа улс төрийн хариуцлага тооцон огцруулав. Улмаар дараагийн даргын төлөөх дотоод сунгаа явуулж, нийт гишүүдийн саналаар тодруулсан юм. Намын даргын төлөөх дотоод сунгаанд таван хүн нэр дэвшин, 40 орчим хоног Монгол орны бүх аймаг, нийслэлийн есөн дүүрэгт гишүүд, дэмжигчидтэйгээ уулзсаны эцэст санал хураалтыг явуулсан.

Санал хураалтын дүнгээр УИХ-ын гишүүн С.Эрдэнэ /2017.01.29/ хамгийн олон гишүүний дэмжлэгийг авч, Ардчилсан намын дарга болов. Тодруулбал, С.Эрдэнэ 2714.45 оноо авсан юм. Харин Н.Алтанхуяг 1640.60, Л.Гантөмөр 1279.43, Ж.Багзандан 1012.36, Д.Эрдэнэбат 801.31 оноо тус тус авчээ. Тус сонгуулийг зохион байгуулахад нийт 1.2 тэрбум төгрөг зарцуулсан бөгөөд уг зардлыг нэр дэвшигчид хуваан гаргасан юм.

3

Хөрөнгө байршуулж болохгүй 42 улсыг зарлав



Монгол Улс оффшорын эсрэг хуулийг анх удаа /2017.04.13/ баталлаа. Ингэснээр оффшор бүс бүхий 42 улсад төрийн албан хаагчид данс нээх, мөнгө байршуулах хориг тавьж байгаа юм. Энэхүү жагсаалтад Сингапур, Хонконг, Швейцар, Бахамын болон Маршаллын арлууд, Бүгд Найрамдах Панам Улс, Пуэрто-Рико зэрэг улс багтаж байгаа.

Гэхдээ төрийн болон улс төрийн албан тушаалтнаас өөр хүнд оффшор данс нээх эрх бий. Харин оффшор бүсэд данс эзэмших, мөнгө байршуулах эрхгүй албан тушаалтны гэр бүлийнхэн нь тус бүсэд данс нээж ашигласан бол өнөөдрийн мөрдөж байгаа Эрүүгийн хуулиар хариуцлага хүлээх заалттай юм.

Дашрамд дурдахад, Ерөнхийлөгч Х.Баттулга оффшор бүсэд данстай улстөрчид, төрийн албан хаагчдыг хөрөнгө мөнгөө Монгол Улсад оруулж ирэхийг уриалсан билээ. Энэ хүрээнд Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсээс явуулсан мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд нийтэд зарлагдсан оффшор бүсээс Монгол Улсын иргэн 4.3 сая ам.доллароо Монгол Улсад оруулж ирсэн. Энэ бол оффшор бүсэд байршуулсан мөнгөн хөрөнгийг буцаан татсан хамгийн анхны тохиолдол юм.



Б.Ганбаяр/ЗГМ ©

Улс төрийн ертөнц 2017 онд

4

Ц.Сандуй огцорч, хотын фракцын эрх хумигдав



“60 тэрбум”-ын гэх асуудалтай нэр холбогдсон Ц.Сандуй НИТХ-ын дарга болон нийслэлийн МАН-ын даргын албан тушаалаасаа огцров. Түүнийг огцруулах операци нийслэлийн МАН-д өрнөж эхлэх үеэ тэрбээр өөрийн хүсэлтээр өргөдлөө өгч, түүнийг нь НИТХ-ын ээлжит бус хуралдаан /2017.09.22/-аар хэлэлцэн, ажлаас нь чөлөөлсөн юм. Харин тэрбээр огцрох болсон шалтгаанаа МАН Ерөнхийлөгчийн сонгуульд ялагдсанд хариуцлага хүлээж байгааг тайлбарлаж байлаа.

Ц.Сандуйгийн хувьд МАН дахь хотын фракцад харьяалагддаг. Нийслэлд МАН олонх болсон он жилүүдэд хотын фракцад бүх эрх төвлөрдөг байсан бол энэ удаа ийн хумигдлаа.

5

Үнэмлэхүй олонхын хоёрдахь Засгийн газар

УИХ дахь үнэмлэхүй олонхоос байгуулагдсан Ж.Эрдэнэбатын Засгийн газар бүрэн эрхээ хэрэгжүүлснээс хойш нэг жил гаруй хугацаанд ажиллаад огцорсон нь оны онцлох үйл явдлын нэг болж байна. Түүний тэргүүлсэн Засгийн газрыг огцруулах бичигт эрх баригч намын бүлгийн 31 гишүүн гарын үсэг зурж, УИХ-д өргөн барьсан юм. УИХ-ын чуулганы хуралдаанд оролцсон 73 гишүүний 42 нь дэмжсэнээр /2017.09.07/ Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ огцров.

Харин дараагийн Засгийн газрын тэргүүнээр У.Хүрэлсүхийг томилж /2017.10.04/, түүнээс хойш хагас сарын дараа /201.10.20/ кабинет нь бүрэлдэв. У.Хүрэлсүхийн Засгийн газар мөн л Монголын түүхэнд анхдагч болох нэг тодотголтой нь бүх сайд нарыг парламентаас томилсон явдал. Өмнө нь Ц.Элбэгдоржийн Засгийн газар /Үндэсний эв нэгдлийн Засгийн газар 2004 он/-ын сайдууд 100 хувь парламентаас бүрдэж байсан ч, энэ нь эвслийнх байсан гэдгээрээ ялгаатай юм.

6

Нам, засгийн удирдлагын эрх нэг хүнд шилжлээ

Монгол Улсын Ерөнхий сайдаар томилогдон, өөрийн кабинетыг эмхлэн байгуулснаас нэг сарын дараа /2017.11.21/ У.Хүрэлсүх намын эрхийг мөн “гартаа авав”.

МАН XXVIII Их хурлаа хийн, намын дарга М.Энхболд өөрийн саналаар улс төрийн хариуцлага хүлээн огцорсон юм. Харин намын дараагийн даргад Ерөнхий сайд У.Хүрэлсүх, УИХ дахь МАН-ын бүлгийн дарга Д.Хаянхярваа нар нэр дэвшин өрсөлдөв. Санал хураалтад намын Их хурлын 1229 төлөөлөгч оролцсоноос 775 буюу 63.1 хувь У.Хүрэлсүхийн төлөө саналаа өгсөн юм. Харин Д.Хаянхярвааг 454 төлөөлөгч дэмжсэн байлаа.

Намын даргад мөн тус намын гишүүн Н.Дэмбэрэл өөрийгөө дэвшүүлсэн бол, ЗГХЭГ-ын дарга асан Ж.Мөнхбатыг заалнаас санал болгосон ч, аль аль нь нэрээ татсанаар өрсөлдөөн дээрх хоёр эрхмийн хооронд өрнөв.

У.Хүрэлсүхийн хувьд МАН-ын түүхэнд 1921 оноос хойш тоолбол 15 дахь, 1996 оноос хойш бол найм дахь дарга нь болж байгаа юм.

7

УИХ хүлээж авдаггүй Ерөнхийлөгчийн хоригууд

Ерөнхийлөгч Х.Баттулга хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ дагуу УИХ-аас гаргасан шийдвэрүүдийн гуравт нь хориг тавилаа.

Эхнийх нь 2017 оны төсвийн тодотголд хэсэгчлэн хориг тавьсан бол удаах нь Сангийн сайдаар Ч.Хүрэлбаатарыг томилсон шийдвэрт хориг тавьсан юм. Харин хамгийн сүүлд буюу энэ сарын 5-нд 2018 оны улсын төсвийн зарлагын хэсэг дээр Ерөнхийлөгч хориг тавьж байгааг Тамгын газрын дарга З.Энхболд мэдэгдсэн юм. Гэхдээ түүний тавьсан хоригуудын алийг нь ч УИХ хүлээж аваагүйг сануулъя.

Дашрамд дурдахад, өмнөх Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн хувьд бүрэн эрхээ найман жил хэрэгжүүлэхдээ нийт таван удаа хориг тавьж байжээ. Харин тухай бүрт нь УИХ хоригийг хүлээж авч байсан аж. Харин Ерөнхийлөгч Х.Баттулгын хувьд хоригийг улс төрийн хүрээнд “Уянгын халилтай, хийсвэрлэл ихтэй, хардалт таамаг дээр үндэслэсэн, шүлэг бичиг байгаа юм шиг толгой холбодог” хэмээх шүүмжлэл их байдаг юм.

8

Н.Энхбаяр байгуулсан намаа бусдад “алдав”

Саяхныг хүртэл “МАХН бол Н.Энхбаяр юм” гэж хардаг, харагддаг байсан нь өөрчлөгджээ.

Ойролцоогоор долоо хоногийн өмнө /2017.12.10/ тус намын Их хурлын 800 гаруй төлөөлөгчийн 600-ийнх нь саналаар Н.Энхбаярыг намын даргаас огцруулав. Улмаар МАХН-аас УИХ-д цор ганцаараа сонгогдсон О.Баасанхүүг намын шинэ даргаар сонголоо.

2016 оны УИХ, орон нутгийн сонгууль болон өнгөрсөн зургадугаар сард болсон Ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүнг хэлэлцэн намын дарга Н.Энхбаяраас улс төрийн хариуцлага нэхсэн нь энэ юм.

Намын даргын төлөөх дотоод сонгуульд О.Баасанхүүтэй хамт нийслэлийн МАХН-ын дарга Г.Бямбасүрэн нэр дэвшсэн юм. Улмаар тэрбээр хуралдаанд оролцсон гишүүдийн 5.6 хувийн дэмжлэгийг авсан байна.

9

Үндсэн хуулийн өөрчлөлт

Өнөөдрийнхтэй нийлээд нийт дөрвөн парламентын бүрэн эрхийн хугацаанд яригдаж буй Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг сая нэг УИХ-д өргөн барихад бэлэн боллоо.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг орон даяар нийт ард иргэдээр хэлэлцүүлэх ажил өндөрлөд байна. Нийт 327375 саналыг иргэдээс авч, үр дүнг нь нэгтгэсэн байна. Харин одоо улс төрийн намуудын саналыг авчигвал төслийг өргөн барина гэдгээ Ажлын хэсгийн ахлагч Д.Лүндээжанцан /2017.12.13/ хэлэв.

Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн саналаас онцолбол Ерөнхийлөгч парламентыг тараах эрхтэй байхыг олон нийт дэмжсэн бол хууль санаачлах эрхийг нь хязгаарлах ёстой гэж үзжээ. Харин Ерөнхий сайдад Засгийн газрын гишүүдээ өөрөө томилж, огцруулах эрхийг нь өгөх ёстой гэсэн байв.

10

С.Баярыг буцаан татахаар болов



ИБУИНВА-д Монгол Улсыг төлөөлөн суугаа Элчин сайд С.Баярыг эргүүлэн татах асуудал улс төрийн хүрээний онцлох үйл явдлын нэг байлаа. Түүнийг Элчин сайдаар очих үеэс л Лондон дахь зарим монгол иргэн эсэргүүцлийн жагсаалаар “угтсан”. Улмаар Ерөнхийлөгч Х.Баттулга /2017.07.19/ С.Баяр болон Шведийн Вант Улсад суугаа Элчин сайд М.Энхсайхан нарыг эргүүлэн татах саналаа УИХ-тай зөвшилцөхөөр хүргүүлсэн нь асуудлыг анхаарлын төвд авчирсан юм. Энэхүү саналын дараа С.Баяр өөрөө Элчин сайдын ажлаас өгөх хүсэлтийг Засгийн газарт ирүүлээд байв.

Тэгвэл Засгийн газрын хуралдаанаас /2017.12.13/ С.Баярыг Элчин сайдаас эргүүлэн татах шийдвэрийг гаргасан юм.

Эдийн засаг

2

Алт тушаалт түүхэн дээд түвшинд хүрэв



Монголбанк энэ оны 11 дүгээр сарын эцсийн байдлаар иргэд, аж ахуйн нэгжүүдээс нийт 19.1 тонн алт худалдан авлаа. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.5 тонноор илүү буюу найман хувиар өссөн үзүүлэлттэй байна. Төгрөгтэй харьцах ам.долларын ханш тогтвортой байхад алт тушаалт гол үүрэг гүйцэтгэж ирсэн. Монголбанкны гадаад валютын албан нөөцийг зузаатгах үүднээс УИХ гурван жилийн өмнө Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Хуульд зааснаар, 2019 он хүртэл дотоодын иргэн, аж ахуйн нэгж татварын хөнгөлөлт эдэлж буй. Төв банкны хувьд Лондоны үнэт металлын захын үнийг мөрдөж байгаа. Энэ нь алтны тушаалт нэмэгдэхэд нөлөөлж буй. Тэрчлэн Засгийн газраас “Алт-2” хөтөлбөр хэрэгжүүлж байна. Энэхүү хөтөлбөрт зааснаар манай улс 2030 он гэхэд жилд 25 тонн алт олборлох түвшинд хүрэх юм.

3

ДНБ 5.8 хувиар өсөж, эдийн засаг идэвхиж эхэллээ



Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн 2016 онд дөнгөн данган нэг хувиар өсөж байсан бол энэ оны гуравдугаар улирлын байдлаар 5.8 хувиар өсөсөөд байна. Сүүлийн дөрвөн жилд тасралтгүй буурч байсан ДНБ ийнхүү өсөлтийн төлөвт шилжсэн нь энэ. Дэлхийн банк манай улсын 2017 оны эдийн засгийн өсөлтийг 2.8 хувиар таамагласан бол Азийн хөгжлийн банк дөрвөн хувиар зураглаж байна. Эдийн засаг 5.8 хувиар өсөхөд, нүүрсний экспортоос гадна үйлчилгээний салбар голлох үүрэг гүйцэтгэв. Эдийн засагт гарч буй эерэг хандлагыг түүхээлэх ДНБ-ий өсөлтөөс гадна төлбөрийн тэнцэл ашигтай гарч, гадаад валютын албан нөөц хоёр тэрбум ам.долларын босгыг давлаа. “Оюутолгой” төслийн гүний уурхайн бүтээн байгуулалт урагшилж, ил уурхайн олборлолт нэмэгдсэн нь ДНБ-ий өсөлтөд түлхэц болж байна.

4

“Монгол зэс” корпораци Улсын дээд шүүхэд яллаа



Монголын хувийн хэвшлийн төлөөлөл “Монгол зэс” корпораци “Эрдэнэт үйлдвэр”-ийн 49 хувийн хувьцаа эзэмшигч болохыг Дээд шүүх баталгаажууллаа. “Эрдэнэт үйлдвэр”-ийн 49 хувийн эзэмшилтэй холбоотой улс төрийн маргаан ийнхүү нэг тийш болов. Энэ нь эдийн засгийн хүндрэлийг давахын тулд гадаадын хөрөнгө оруулалтыг өсгөхөөр зорьж буй Монгол Улсын хувьд хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээхэд эерэг дохио боллоо. “Монгол зэс” корпорацийн оролцоо, хяналт “Эрдэнэт үйлдвэр”-т бий болсноор ил тод байдал сайжирч, бизнесийн зарчмаар илүү үр ашигтай ажиллаж эхэлсэн. Тус үйлдвэр 2016 онд ганцхан удаа нээлттэй тендер явуулсан бол хувийн хэвшлийн хяналт бий болсноор 2017 онд энэ тоо 491-д хүрчээ. Мөн худалдан авалтыг илүү үр ашигтай болгох менежмент хэрэгжүүлснээр зөвхөн бараа материал, сэлбэг хэрэгслийн үнийн зөрүүнээс гэхэд 15.1 тэрбум төгрөг хэмээн юм.

5

ОУВС-д эдийн засгийн жолоогоо даатгав



Он дамнасан хэлэлцээрийн үр дүнд хямралд цэг тавих ОУВС-гийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т Монгол Улс энэ оны нэгдүгээр улиралд хамрагдав. Ингэснээр 36 сарын хугацаатай хэрэгжих хөтөлбөрийн хүрээнд манай улсын эдийн засагт 5.5 тэрбум ам.долларын санхүүжилт татах боломж бүрдсэн юм. Төсөв болон төлбөрийн тэнцлийн хос алдагдалд орсон эдийн засгийг “эмчлэх” учиртай хөтөлбөрийн үр дүнд ДНБ дунд хугацаанд 8.1 хувьд хүрч, инфляц зургаан хувьд тогтворжих төсөөллийг ОУВС гаргасан. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх болсноор төсвийн зардлыг хумихаар болж, төсөв, мөнгөний хатуу бодлого хэрэгжиж эхэллээ. Хөтөлбөрийн хүрээнд хувийн хэвшил болон иргэдийн нуруун дээр ирэх татварын ачаалал нэмэгдлээ. Монголбанк ипотекийн хөтөлбөрийг Засгийн газарт шилжүүлэхээр болж, төсөвт зээлийн эх үүсвэр нэмж суулгав.

Уналтаас өсөлт рүү зүтгэсэн жил



С.Батсайхан / ЗГМӨ

6

“Эрдэнэс Тавантолгой”-н өр нимгэрч, экспорт нэмэгдлээ



Эрдэс, түүхий эдийн экспорт энэ оны эхний 11 сарын байдлаар 4.5 тэрбум ам.доллартай тэнцэж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 33 хувиар өсөв. Ингэснээр улсын нийт экспортын 79 хувийг дангаар бүрдүүллээ. Эрдсийн экспортыг орлогын дүнгээрээ нүүрсний экспорт тэргүүлж, тайлант хугацаанд биет жингээр анх удаа улсын хэмжээнд 31.9 сая тонн хүрч, орлого нь 2.12 тэрбум ам.доллартай тэнцээд байна. Эдийн засаг 5.8 хувиар өсөж, төсвийн орлого давж биелэхэд нүүрсний экспорт жин дарлаа. Тухайлбал, “Эрдэнэс Тавантолгой” компани энэ жил 13 сая тонн нүүрс олборлож, 11.5 сая тонныг экспортлохоор төлөвлөсөн. Тус компани энэ оны гуравдугаар улиралд 343 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж, таван жил сунжирсан “Чалко”-гийн өрөө энэ оны эхэнд бүрэн барагдуулсан. Үүнээс гадна “Эрдэнэс Тавантолгой” компани Монгол Улсын Хөгжлийн банкнаас олгосон 200 сая ам.долларын зээлээс 100 сая ам.долларыг эргэн төлөлтийн хуваарьт хугацаанаас нь өмнө төлж барагдууллаа.

7

“Хар жагсаалт”-аас үүдэн бизнесийн боломж хумигдлаа



Европын холбоо анх удаа татварын “диваажин” болсон улс орон, бүс нутгийн “хар жагсаалт”-ыг олон улсад дэлгэв. Үүний дотор Монгол Улс багтаж, улмаар бизнес, худалдаа, хөрөнгө оруулалтын орчин тодорхой бус байдал үүслээ. Эдийн засаг, улс төрийн нэгдэл түүхэндээ татварын сул тогтолцоотой орнуудад хариуцлага тооцож, хар болон саарал жагсаалтаар “бэлэг” барив. Харилцан ашигтай татварын төлөө Европын холбоотой идэвхтэй хамтарч ажилладаггүй 17 оронд шахалт үзүүлж, худалдааны салбарт албан бус хориг тогтоолоо. Уг хоригоос гарахад хамгийн багадаа нэг жилийн хугацаа шаардлагатай бөгөөд манай улсын хувьд Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулахаар болж байна. Тэрчлэн татварын мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлын Дэлхийн форумын гишүүн болох шаардлага үүсэв. Европын холбоо болон Монгол Улсын хоорондох худалдааны нийт үнийн дүн өнгөрсөн онд 500 сая еврог давсан. Монголоос тус холбоонд гаргасан экспорт гэхэд 100 сая руу дөхсөн бол Европын холбооноос Монголд нийлүүлсэн экспорт 350 сая евро болсон байна.

8

Багш нараа үнэлдэггүй төр 300 мянгыг тараахаар болов



Боловсролын салбарт хүчин зүтгэж яваа ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нар цалингаа нэмүүлэх гэж хэдэнтэй албан бичиг үйлдэж, Засгийн газарт удаа дараа хандсан боловч үр дүнд нь сайн мэдээ дуулсангүй. Хичээлийн шинэ жилтэй хамт эхэлсэн тэмцэл хот, хөдөөгүй өрнөж, эрчээ авсан боловч гурван талт хэлэлцээрийн явцад намжлаа. Багш нар цалингаа гурав дахин буюу 1.6 сая төгрөг болгохоор шаардсан нь цагаа олоогүй гэсэн эсэргүүцэлтэй тулж, салбарын сайдынхаа дэмжлэг авч чадсангүй. Төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнээс давсан ч цалин нэмэх боломжгүй хэмээн Засгийн сайд Ч.Хүрэлбаатар гэдийлээ. Засгийн газар багш нарын цалинг нэмэхээс цааргалсан атлаа төрийн албан хаагчдад 300 мянган төгрөгтэй тэнцэх нэг удаагийн тэтгэмж олгохоор шийдэв. Боловсролын салбарт ажиллаж буй багш нар хамгийн багадаа 400 хүрэхгүй мянган төгрөг гар дээрээ авдаг. Багш нарын цалинг төрөөс хамгийн сууд буюу 2014 онд 80 мянган төгрөгөөр нэмсэн. Үүнээс хойш төгрөгтэй харьцах ам.долларын ханш хоёр дахин өсөж, өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний 2-3 дахин өсөөд байна.

9

Их наяд үнэлгээтэй анхны компанийг АПУ тэргүүлнэ



Монголын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2017 он гарснаас хойш 58 хувиар өсөж, 2.3 их наяд төгрөгт хүрэв. ТОП-20 индекс 21 мянган нэгжийн түвшнийг давж, 70 гаруй хувиар өссөнөөр дэлхийн индексүүдийг өсөлтөөрөө тэргүүллээ. Ингэснээр эдийн засаг сайн байсан 2011 оны түвшинд хүрээд зогссонгүй өсөлт цааш үргэлжилж байна. Монголын хөрөнгийн бирж их наядаар үнэлэгдэх анхны компанийнхаа хувьцааг арилжих цаг улам ойртлоо. Тодруулбал, АПУ хувьцаат компани MCS-ийн ус, ундааны бизнесийг өөртөө нэгтгэснээр зах зээлийн үнэлгээ нь 960 тэрбум төгрөгт хүрч, Монголын хамгийн үнэ цэнэтэй нээлттэй компани болоод байна. Монголын бизнесийн салбарт нэгдэн нийлэх, салбар нэгжээ худалдах хэлцэл сүүлийн үед идэвхижиж байгаа нь энэ. Ноолууран бүтээгдэхүүний зах зээлд өрсөлдөгч гэж хэлж болох “Тоёо” компанийг “Таванбогд” групп худалдан авч, “Товь” компани хүчээ улам зузаатгав. Мөн “Макс” групп газрын тосны салбарт хүч үзэхээр шийдсэн бол “Алтай” групп хөдөө аж ахуйн салбараар үйл ажиллагаагаа тэлж байна.

10

Хөгжлийн банкны өрийг хугацаанд нь төлж, итгэл хүлээлээ



Засгийн газар ээлжит бондоо “Хуралдай” нэрээр олон улсын зах зээлд гаргаж, Монгол Улсын Хөгжлийн банкнаас 2012 онд гаргасан 580 сая ам.долларын бондыг хуваарийн дагуу амжилттай эргэн төллөө. 2016 оны гуравдугаар сард олон улсын санхүүгийн зах зээлд “Мазаалай” бондыг 10.875 хувийн хүүтэй арилжиж байсан бол энэ оны гуравдугаар сард “Хуралдай” бондыг 8.75 хувийн хүүтэйгээр борлуулав. Засгийн газар 600 сая ам.долларын бонд нийлүүлсэн ч эрэлт нь үүнээс 5-6 дахин их буюу 3.3 тэрбум ам.доллар байсан юм. Олон улсын зах зээлд нээлттэй арилжсан “Хуралдай” бондын 76 хувийг АНУ-ын хөрөнгө оруулагчид, 18 хувийг Европын хөрөнгө оруулагчид авсан бол Азийн хөрөнгө оруулагчид зургаан хувийг бүрдүүлсэн билээ. “Хуралдай” бондын үндсэн төлөлт 2024 онд хийгдэнэ. Засгийн газрын баталгаатай гарсан Хөгжлийн банкны 580 сая ам.долларын бондыг шинэ бондоор солих ажил амжилттай хэрэгжиж, хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ Монгол Улс биелүүлээ.